

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР

Өдөр +14
Шөнө +6

УЛС ТӨР

СУ.БАТБОЛД: Л.ЭРХЭМБАЯР МАН-ЫН ГИШҮҮДИЙН НЭР ТӨРД ХАЛДСАН УЧРААС ШҮҮХЭД ӨГСӨН

II нүүрт

ШУУРХАЙ МЭДЭЭ

Ч.САРАНТУЯА: ЭНЭ ЗУН ХУР БОРОО ИХТЭЙ БАЙНА

VII нүүрт

Дугаарын 60 мөр

Аялал эхэллээ, амрагчдаа угтахад бэлэн үү
Б.ӨНӨРТӨГТӨХ

Өнөөдөр нар буцаж, усны хор тайлагдаж байна. Намуудын улс төрийн синдром дуусахад долоо хоног үлджээ, наадам эхлэхэд харин 18 хоног үлджээ. Хангай дэлхий ч хураа харамгүй хайрлаж, байгаль ээж ногоон гоёлоо өмсч, ёстой л ойрын хэдэн жил үзээгүй сайхан зун болох нь гэсэн яриа хэдийнэ гарч эхэлчихэж. Улс төрийн сонгуулийн сурталчилгаа дээр дооргүй өрнөсөн энэ үед нийгэм тэр хэмжээгээр бухимдалтай байх шиг. Тиймдээ ч хүн бүхэн л сонгууль дуусч албан ёсны амралтаа авахыг тэсч ядан хүлээж буй нь илт. Хаагуур аялах вэ гэдэг маршрутаа хуртгал гаргачихсан, наадмын ес хоногийн амралтаар ёстой л шавайгаа хангатай зугаалахаар төлөвлөж байгаагаа цахим хуудсаар нэг ярьцгааж байгаа билээ. Ерөөс жилийн жилд л зуны амралтаар нийслэлд цөөхөн хүмүүс үлддэг.

Үргэлжлэл нь III нүүрт

ХАРЬЦУУЛСАН СУРВАЛЖЛАГА



Үнэ дагаж үйлчилгээ гэдгийг

ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН, ПАРК хоёроос харлаа

–Эко цэцэрлэгт хүрээлэн хар зах болж хувирчээ–

Сурвалжилсан: **Н.БАТЗАЯА**
Б.САРНАЙ
Х.НАРАНЦАЦРАЛ

Ногоон навчис сэргчигнэж, өнгө өнгийн цэцгийн мандал дэлбээлж, хүүхэд, залуус хөгжилдөн нийслэлд маань аль хэдийнэ зун цаг иржээ. Нар хур тэгширсэн зуны нарлаг өдрүүдэд Үндэсний цэцэрлэгт хүрээлэн, Үндэсний соёл, амралтын хүрээлэнг зорих иргэдийн тоо ч ихэслээ. Сая гаруй хүн амтай Улаанбаатар хотод гэр бүлээрээ ая

тухтай амарч, тухлах басхүү хөдөөнөөс ирсэн нэгэндээ сонин болгож үзүүлэх газрын тоонд яалт ч үгүй дээрх хоёр газар ордог болжээ. Эдгээр хүрээлэнг зорих хүмүүсийн тоо манай улсын иргэдээр ч хязгаарлагдахгүй. Жилийн 250 өдөрт нартай байдаг монголын цэлмэг тэнгэрийг харах гэж ирсэн жуулчдын хамгийн эхний саатах газар нь Улаанбаатар хот. Аяллын хөтөч, тайлбарлагчдын жуулчиддаа үзүүлэх тоотой хэдэн газрын нэг нь мөн л дээрх хоёр хүрээлэн. Манай оронд

өнгөрсөн жил 386204 жуулчин ирсэн гэсэн статистик мэдээлэл гарчээ. Эндээс Монголын нийслэл Улаанбаатар хотын талаарх жуулчдын үнэлэмжийн нэг хэсэг нь дээрх хүрээлэнгүүдээс шалтгаалдаг болсон гэж хэлж болохоор. Тиймээс бид жуулчид гэлтгүй нийслэлчүүдийн амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх дуртай Үндэсний цэцэрлэгт хүрээлэн болон Үндэсний соёл, амралтын хүрээлэнгээс энэ удаагийн сурвалжлагаа бэлтгэлээ.

Үргэлжлэл нь IV-V нүүрт

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

Газрын наймааны мөнгөөр 26 мянган цэцэрлэг барих байжээ

Н.БАТЗАЯА

Нийслэлчүүдийн толгой өвтгөсөн асуудлын нэг нь хууль бус газар олголт байсаар ирсэн. Сургууль цэцэрлэг, нийтийн эзэмшлийн талбайд хэн нэгэн эрх дархтаны хууль бус зөвшөөрлийн дагуу барилга, байшин барих эрх олгож байсан үйлдэл удаа дараа гарч байсан билээ. Гэсэн ч олны нүднээс далд явагддаг уг хууль бус үйлдлийн талаарх томоохон тоо баримт байхгүй байгаа юм. Тэгвэл “Зүтгэл, сэтгэл, итгэл Эх-орон” төрийн бус байгууллага өчигдөр Чингисийн талбайд “Газраа алдал бүхнээ алдана” нэртэй үзэсгэлэн зохион байгууллаа. Энэхүү үзэсгэлэнд хууль бусаар олгогдсон газрыг дэлгэн, олонд танилцуулсан юм. Үзэсгэлэнгийн нээлтийн үеэр тус төрийн бус байгууллагын тэргүүн С.Отгонцэцэг “Хүн аливаа нэгэн зовлонг биеэрээ туулж, мэдэрч байж л ойлгож, мэдэрдэг. Би 2008 онд нэг газраа алдсан.

Үргэлжлэл нь II нүүрт

ХӨНДӨХ СЭДЭВ

Дагуул хотуудыг “ДАГАВАР ХҮҮХЭД” мэт болгосон түүх

Д.СҮХ

Налайх, Багануур дүүргийг Улаанбаатар хотын дагуул хот болгож, хөгжлийн үндэс суурийг нь тавилаа хэмээн нийслэлийн удирдлагууд баярлаж хөөрч байсан цаг саяхан. Гэвч цаг үеэ олсон энэ санал санаачилга, бие даасан хот шиг хот болох ард иргэдийн хүсэл тэмүүллийг эрх баригчид үнэндээ “хайчлаад”

хаясантай адил сонголтыг тэдэнд өглөө.

Учир юу гэвэл УИХ-ын сонгуулийн тойргийн хуваарилалт хийхдээ дагуул хотуудыг хотын дүүргүүдийн бөөрөнд нааж орхив. Багануур хотыг Сүхбаатар дүүргийн хавсарга болгочихлоо. Тав, зургаан хороог нь нэг, хоёроор нь Сүхбаатар дүүргийн дөрвөн тойрогт хуваарилав. Налайх

хотыг Чингэлтэй дүүргийн 63 дугаар тойргийн мэдэлд шилжүүлэв. Харамсалтай нь дагуул хотуудад хойд эхийн сэтгэлээр хандаж байхад дагуул хотуудыг босгосон Улаанбаатар хотын багийнхан огтхон ч дуугарсангүй. Хотын дарга Э.Бат-Үүл хамгаалж ганц ч үг ганхийсэнгүй.

Үргэлжлэл нь III нүүрт

ҮЗЭЛ БОДОЛ

ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН ЯВЦЫГ ГАДНЫХАН ИНГЭЖ ДҮГНЭЖЭЭ


Б.ДАВААХҮҮ

Монголчууд ердөө найм хоногийн дараа төрийн хууль тогтоох дээд байгууллагын төлөөлөө сонгох Үндсэн хуулиар олгогдсон эрхээ эдлэх гэж байна. Сонгуулийн сурталчилгаа шинэ хуульд заасан ёсоор 18 хоногийн хугацаанд үргэлжлэх бөгөөд энэ сарын 11-ний өдөр албан ёсоор эхэлсэн билээ. 12 нам, гурван эвсэл, бие даагчдаас бүрдсэн нийтдээ 498 нэр дэвшигч улс орон даяар сурталчилгаагаа эхлүүлж, цахим ертөнцөөр инээмсэглэн зогсох нэр дэвшигчдийн зураг хөглөрөх аж. Нэг намын тогтолцоот хоёр том гүрний дунд орших атлаа “Ардчиллын баян бүрд” хэмээх том тодотголыг дэлхийд нэртэй улстөрчөөс сонссон Монгол Улсын парламентын бүх нийтийн сонгууль жилээс жилд л олон улсын анхаарлыг илүүтэй татдаг. Улсын хууль тогтоох байгууллагад дараагийн дөрвөн жил суух төлөвлөл сонгогдох мөч ойртох тусам гадны хэвлэл Монголыг илүүтэй анхаарч буйг ч энд дурьдах хэрэгтэй болов уу. Тиймээс ид дундаа өрнөж буй сонгуулийн сурталчилгааны явцыг гадны хэвлэлд хэрхэн мэдээлснийг уншигчиддаа сонирхуулахаар тоймоллоо.

Сонгуулийн ирц 50 хувьд хүрэхгүй байж болзошгүй

Британийн Колумбын их сур-

гуулийн профессор Жулиан Дьеркес Монгол дахь сонгуулийн уур амьсгалын талаарх нийтлэл бичжээ. Түүний таамаглаж буйгаар энэ удаагийн парламентын сонгуулийн ирц зарим бүс



Halfway through Sonuul 2016 Campaign

By Julian Dierkes

The election campaign for the State Great Khural election on June 29 is over halfway through its official 30-day period. While it has been an active campaign for the 498 candidates, and visibly so, it has been politically or substantively lackluster.

Political Substance

I have frequently commented in the past that Mongolian political parties do not offer much of a chance for citizens to give voice to their political views or preferences for the future of the country, as the parties are not defined by political platforms, but rather by personalities and patronage relations.

нутагт 50 хувьдаа хүрэхгүй байж болзошгүй гэнэ. Профессорын бичсэн нийтлэл “Улс төрийн байдал” болон “Хар ба цагаан шар” гэх дэд гарчигтай байв. Эхний хэсгийн бичвэрт “Би Монголын улс төрийн намууд улс орны ирээдүйнхээ төлөө хэвлэн нийтэлж, улс төрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг иргэддээ олгохгүй байгаад харамсч байна.

Үргэлжлэл нь III нүүрт

МОНГОЛ АРДЫН НАМ ХАНДИВЫН ДАНСАА НЭЭЛЭЭ

“ХААН БАНК”
5115028001 тоот данс

Иргэн та хандив өргөхдөө
Сонгуулийн тухайн хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу:
50.1.1 Иргэн гурван сая төгрөг хүртэл /регистрийн дугаар/
50.1.2 Хуулийн этгээд арван таван сая төгрөг хүртэл //регистрийн дугаар/

Сонгуулийн тухай хуулийн 40.3 д:
... “Сонгуулийн зардлын мөнгөн хөрөнгийг банкинд нээлгэсэн, сонгуулийн зардлын дансанд энэ хуульд заасан журмын дагуу төвлөрүүлж, зориулалтын дагуу зарцуула” гэсэн, заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлын 2016 оны ээлжит сонгуулийн зардлын дансыг нээсэн тул намын гишүүд, дэмжигчид, дэмжигч байгууллага, иргэд та бүхнийг хандив өргөхийг хүсье.

МОНГОЛЫН МЭДЭЭ

18 дахь жилдээ

Манай Сонины III улирлын захиалга үргэлжилж байна

Захиалгын үнэ 15400

Улиралд 44 дугаар

Монгол шуудан: 70078977
УБ шуудан: 70127027
Скай пост: 70121294
Түгээмэл шуудан: 70115025

ХААН Банк				Хугалгаа хөгжлийн банк				
	Авах	Зарах		Авах	Зарах		Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	1938.00	1953.00	ФУНТ	2803.00	2886.00	АМ.ДОЛЛАР	1940.00	1953.00
ЕВРО	2175.00	2228.00	РУБЛЬ	28.40	32.30	ЕВРО	2171.00	2231.00
ИЕН	18.32	18.99	ЮАНЬ	293.00	297.80	ИЕН	18.38	18.95
						ЮАНЬ	293.30	297.60

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

УЛС ТӨР

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Мөн бас нэг жижиг газраа 2012 онд алдсан юм. Газраа алдах зовлонг биеэрээ мэдэрсэн болохоор 2008 онд “Эрс шинэчлэл” төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж эхэлсэн. Харин 2009 онд Газрын тухай хуультай холбоотой зөрчил, газрын маргааныг багасгах зорилгоор хэвлэлийн бага хурал хийн иргэд, аж ахуйн нэгжүүдтэй хамтарч ажилласан. Манай байгууллага хохирсон иргэд, аж ахуйн нэгжийг төлөөлөн, тэдний эрх ашгийг хамгаалахын төлөө хотын үе үеийн дарга нарын газар олголтын хууль бус шийдвэрүүдийг эсэргүүцэн олон жил ажиллаж байгаа боловч үр дүн муутай явж ирсэн. Энэ удаад бид дарга нарын хууль бусаар олон нийтийн эрх ашгийг зөрчиж олгосон газрын зураг, гэрчилгээгээр үзэсгэлэн гаргаж, олон түмэнд танилцуулахаар дэлгэж байгаа. Өнгөрсөн 12 жилийн хугацаанд хууль бусаар олгогдсон газрыг олон нийтэд танилцуулах зорилготой энэхүү үзэсгэлэнг зохион байгуулж байгаа юм. Уг үзэсгэлэнд дэлгэгдсэн зарим хууль бус материалуудыг иргэд болон аж ахуйн нэгжүүд хамтарч Нийслэлийн өмчийн харилцааны газарт хүсэлт гаргасны үр дүнд оллоо. Харин зарим материалуудыг иргэд, аж ахуйн нэгжүүдийн тусламжтайгаар авсан юм. Нийт 67 хууль бус газрын материал цуглуулсан. Одоогийн байдлаар 49 материалыг үзэсгэлэнд дэлгээд байна. Бидний зохион байгуулж буй үзэсгэлэн ямар нэгэн намын захиалга, улс төрийн зорилготой биш. Харин ард иргэд сонгуулийн сурталчилгаа явж буй эдгээр өдрүүдэд идэвхтэй байдаг тул өөрсдийнх нь эрх зөрчигдөж, хууль бусаар, нийтийн эзэмшлийн

ГАЗРЫН НАЙМААНЫ МӨНГӨӨР 26 МЯНГАН ЦЭЦЭРЛЭГ БАРИХ БАЙЖЭЭ



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН



талбай, ногоон байгууламж, сургууль, цэцэрлэг, хүүхдийн тоглоомын талбайг дээрэмдэн олгосон шийдвэрүүдийг илүү анхааралтай хүлээн авах боловч уу гэж найдсан учраас энэ өдрүүдэд зохион байгуулахаар болсон” гэсэн юм. Мөн тэрбээр Нийслэлийн өмчийн харилцааны газарт хамтран ажиллах санал тавьсан боловч хүлээж аваагүй гэдгийг онцлолоо. “Зүтгэл, сэтгэл, итгэл Эх-орон” төрийн бус байгууллага нь 2009 оноос хойш иргэд болон аж ахуйн

нэгж байгууллагуудтай хамтран Газрын тухай хуулийг хэрэгжүүлэх, газрын асуудалтай холбоотой маргаануудыг шийдвэрлүүлэхэд идэвхтэй оролцож иржээ. Гэсэн хэдий ч хотын удирдлагуудын төлөвлөгөө, хууль зөрчиж олгосон газрын зөвшөөрлийн улмаас олон иргэн, байгууллага, аж ахуй нэгж, цэцэрлэг, сургуулиуд маш ихээр хохирч байгаа гэдгийг “Зүтгэл, сэтгэл, итгэл Эх-орон” төрийн бус байгууллагын гишүүд хэлж байсан юм. Үзэсгэлэнгийн үеэр

газрын наймаа, гарын үсгээр хууль бус олголт хийсэн дарга нарын нэрийг өөрсдийнх нь зурагтай дэлгэлээ. Тухайлбал, хууль бусаар газар олгосон дарга нарын тоонд хотын даргаар ажиллаж байсан Г.Мөнхбаяр, Ц.Батбаяр, Т.Билэгт нарын нэр бүхий хүмүүс багтжээ. Дээрх дарга нарын хууль бусаар олгосон газрын үнэд Дэлхийн банкаас судалгаа хийсэн аж. Судалгааны үр дүнд нийт 26 их наяд 976 тэрбум 42 сая төгрөгтэй тэнцэх хэмжээний нийтийн эзэмшлийн газрыг олгосон нь тогтоогджээ. Мөн тус үзэсгэлэнд хууль бусаар олгосон газруудыг дэлгэлээ. Тодруулбал, “Ачлал” их дэлгүүрийн хойд талын нийтийн эзэмшлийн талбай, хүүхдийн 100-д байрлалтай ногоон байгууламж, Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн хойд талын явган хүний зам

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

Япон улсад залуу боловсон хүчнээ сургах боломж бүрдлээ

Гадаад хэргийн сайд Л.Пүрэвсүрэн Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар хэрэгжих 555 сая иэний /9 тэрбум 900 сая орчим төгрөг/ үнийн дүн бүхий “Хүний нөөцийг хөгжүүлэх тэтгэлэгт хөтөлбөр-JDS” төслийг хэрэгжүүлэх тухай Монгол, Японы Засгийн газар хооронд солилцох ноот бичигт өчигдөр гарын үсэг зурлаа. Энэхүү хөтөлбөр нь зах зээлийн эдийн засагт шилжсэн улс орнуудын хүний нөөцийн хөгжлийг дэмжих зорилготой. Түүнчлэн тухайн орны хөгжилд хувь нэмэр оруулах ирээдүйтэй залуу төрийн албан хаагчдыг Япон Улсын их дээд сургуульд суралцуулж, мэдлэг олгодог нэн чухал ач холбогдолтой хөтөлбөр юм. “Хүний нөөцийг хөгжүүлэх тэтгэлэгт хөтөлбөр-JDS” төслийг Япон Улсын Засгийн газар хөгжиж буй улс орнуудын хүний нөөцийн хөгжлийг дэмжих зорилгоор 1999 оноос хэрэгжүүлж эхэлсэн.

Өдгөө Монгол, Индонез, Филиппин, Хятад, Лаос, Узбекистан, Камбож, Вьетнам, Гана зэрэг нийт 12 улсад

хэрэгжиж байна. Монгол Улс тус хөтөлбөрт 2001 онд хамрагдаж, өнөөг хүртэл нийт 14 төсөл хэрэгжиж, 262 залуу төрийн албан хаагч хамрагджээ. Төслийн хүрээнд Монголын нийгэм, эдийн засгийн хөгжлийн асуудлуудад хувь нэмэр болохуйц нийгмийн ухааны чиглэлд төвлөрсөн хууль, эдийн засаг, төрийн удирдлага зэрэг мэргэжлүүдээр боловсон хүчин бэлтгэдэг.

2015 онд хэрэгжсэн энэхүү хөтөлбөрт манай улсын 18 төрийн албан хаагч хамрагдаж, Япон Улсын их дээд сургуулийн магистрантурт суралцаж байгаа аж. Цаашид энэ хөтөлбөрийн хамрах хүрээ өргөжиж, хувийн хэвшлийн төлөөлөл хамрагдах боломжтой болох юм. 2016 онд Монгол Улсаас 22 хүн энэ төсөлд хамрагдана. Үүний 18 нь залуу төрийн албан хаагч байх бөгөөд хоёр нь хувийн хэвшлээс, хоёр нь доктрантурын сургалтад хамрагдах юм байна. Уг төсөл 2016 оноос хоёр үе шаттайгаар долоон жилийн /3 жил, 4 жил/ хугацаанд хэрэгжинэ.

Өнөөдрөөс санал асуулга явуулахгүй

Хуулийн хүрээнд улс төрийн нам, эвслүүд сонгуулийн сурталчилгаа хийж байгаа. Хэдийгээр сурталчилгаа үргэлжилж байгаа ч нам, нэр дэвшигчийн талаар санал асуулга явуулах, нийтлэх, тараахыг хуульд заасанчлан өнөөдрөөс эхлэн хориглож байгаа. Тодруулбал

Сонгуулийн тухай хуулийн 70.2-т “Аливаа этгээд санал авах өдөр хүртэлх долоо хоногийн хугацаанд нам, нэр дэвшигчийн талаар санал асуулга явуулах, энэ төрлийн мэдээллийг, бүх төрлийн мэдээллийн хэрэгсэл ашиглан нийтлэх, тараахыг хориглоно” хэмээн заажээ.

МЭДЭЭЛЭЛ

АСЕМ-ийн үеэр хэрэглэх “ASEM tag” наалтыг танилцуулав

Улаанбаатар хотноо АСЕМ-ын дагалдах хурлуудын нэг болох Ази европын хүнсний аюулгүй байдлын зөвлөлдөх уулзалт хоёр өдөр үргэлжилж өчигдөр дууслаа. Хүнсний үйлдвэрлэл, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал, хоол тэжээл гэсэн гурван үндсэн сэдвийн хүрээнд өрнөсөн энэхүү зөвлөлдөх уулзалтын үеэр Монголын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, байгаль орчны нийгэмлэгээс санаачлан гаргасан “ASEM tag” наалтыг уулзалтад оролцогчид танилцууллаа. АСЕМ-ын зочид төлөөлөгчдөд баталгаагүй хүнсний түүхийг эд, бүтээгдэхүүнээр үйлчлэхээс сэргийлэх зорилгоор үйлчилгээ үзүүлэх эрх авсан аж ахуйн нэгж, байгууллагын бараа, бүтээгдэхүүнд “ASEM tag” наалтыг хэрэглэх тухай Нийслэлийн Засаг даргын захирамж гарсан билээ. Уг наалт nano технологид суурилсан, хүний биеийн дулаан, гэрлийн хувирлаар бүтээгдэхүүний чанарыг тодорхойлдоороо онцлогтой аж. Хүнсний бүтээгдэхүүн дээр тусгай наалт байрлуулснаар чанарын шаардлага хангасан эсэхийг хэрэглэгч болон бүтээгдэхүүн нийлүүлэгч аж ахуйн нэгж өөрсдөө богино хугацаанд шалгах боломж бүрдэх юм.

ХЭВЛЭЛИЙН ХУРАЛ

Су.БАТБОЛД: Л.Эрхэмбаяр МАН-ын гишүүдийн нэр төрд халдсан учраас шүүхэд өгсөн

Б.ЭРХЭС

УИХ-ын гишүүн Су.Батболд өчигдөр Тусгаар тогтнолын ордонд иргэний бүртгэл, шилжилт хөдөлгөөнтэй холбоотой асуудлаар мэдээлэл хийлээ. Сүүлийн үед иргэний шилжилт хөдөлгөөн эрчимжиж, зарим аймгууд руу бүр 3000 гаруй иргэд шилжсэн тухай мэдээлэл цацагдаж буй. Тэгвэл МАН-

...АН-ын зүгээс мэдээлэл хийхдээ сонгогчдын шилжилт хөдөлгөөнийг МАН-ын гишүүд хийсэн мэтээр ойлгуулсан учраас энэ асуудлыг шалгуулахаар Л.Эрхэмбаяр генсекийг шүүхэд өгчээ. Шилжилт хөдөлгөөнийг нарийвчлаад гаргавал аль намын хэн нь шилжүүлээд байгаа нь тодорхой болно...

ын зүгээс Бүртгэл статистикийн газраас энэ асуудлаар нэгдсэн мэдээлэл авчээ. Тус газраас өгсөн мэдээллээр сүүлийн нэг сарын хугацаанд Монгол Улсын хэмжээнд 18 мянга гаруй сонгогч шилжилт хөдөлгөөн хийлгэсэн байна. 600-аас дээш буюу их хэмжээний шилжилт хөдөлгөөн хийгдсэн аймгуудыг тэрбээр нэр цохон онцолсон юм. Тодруулбал, Архангай аймагт 1341, Баянхонгор аймагт 2059, Дархан-Уул 694, Дундговь аймагт 772, Завхан аймагт 600, Сэлэнгэ аймагт 631, Увс аймагт 3237 сонгогч, Төв аймагт 826, Ховд аймагт 717, Хөвсгөл аймагт 2943, Өвөрхангай аймагт 897 сонгогч тус бүр шилжиж, нийт дүнгээр 17189 сонгогч шилжиж очжээ. Су.Батболд гишүүн “УИХ-ын сонгууль нэг мандат нэг тойрог гэсэн зарчмаар буюу 76 жижиг мөжаритор тогтолцоогоор явагдаж байгаа. Сонгуулийн тойрогт дунджаар 25 мянга орчим сонгогч оногдож байгаа. Гэтэл сонгуулийн үеэр нийм их шилжилт хөдөлгөөн хийгдсэн нь сонгогчдын дүнд нөлөөлөх

асуудал үүсгэж байна. Тиймээс манай намын Сонгуулийн төв штабаас нэлээд санаа зовж байгаа. Бүртгэл статистикийн төв газар, СЕХ болон бусад газруудад олон тооны мэдэгдэл явуулсан. Сонгогч уг нь өөрийн биеэр очиж шилжилт хөдөлгөөн хийлгэх ёстой. Гэтэл нэг хүн 100 орчим хүний иргэний үнэмлэх авч очиж шилжилт хөдөлгөөн хийлгэж байгаа асуудал гарч байна. Төв аймгийн 30 дугаар тойрогт нэг шөнийн дотор 400 гаруй сонгогчдыг бүртгүүлсэн зөрчил гарсан. Гэртээ унтаж байхад нь дуудаж аваачаад бүртгүүл хэмээн шахаж шаардсан зөрчил гарлаа. Энэ бүхнийг баталгаажуулж хууль хяналтын байгууллагад өгөхөөр болж байна” гэв. Мөн АН-ын зүгээс мэдээлэл хийхдээ сонгогчдын шилжилт хөдөлгөөнийг МАН-ын гишүүд хийсэн мэтээр ойлгуулсан учраас энэ асуудлыг шалгуулахаар Л.Эрхэмбаяр генсекийг шүүхэд өгчээ. Шилжилт хөдөлгөөнийг нарийвчлаад гаргавал аль намын хэн нь шилжүүлээд байгаа нь тодорхой болно. Тиймээс сонгогчдын саналд бодитоор нөлөөлж буй үйлдлийг таслан зогсоохыг бүх нам эвслүүдэд уриалж байна гэв. Мөн МАН-ын хууль хяналтын ажлын хэсэг нийслэлийн 100 гаруй сонгуулийн хороонд очиход хэд хэдэн зөрчил илрүүлжээ. Хаяг дээрээ бүртгэлгүй хүмүүсийг олон тоогоор бүртгэсэн тохиолдол гарчээ. Нэг хашаанд гэхэд л 10 гаруй залуусыг бүртгэсэн асуудал Сүхбаатар дүүрэгт гарсан аж. Мөн хэсгийн хороонд нэг намын төлөөлөл ажиллаж байгаа гэсэн зөрчил илэрсэн байна. Түүнчлэн, сүүлийн үед хэвлэл мэдээллийн хэрэгслээр Япон улс руу 100.000 дадлагажигч гаргана гэсэн мэдээлэл явж байна. Энэ бол Сонгуулийн хуульд заасан хэн нэгэнд амлалт өгч болохгүй гэсэн заалтыг зөрчиж байгааг Су.Батболд гишүүн хэллээ. Тэрбээр, Япон Монголын бүлгийн даргаар 10 гаруй жил ажилласан. Японы хууль тогтоомжоор дадлагажигч хүлээж авах асуудлыг нарийн зохицуулсан байдаг гэсэн юм. Хоёр орны харилцаанд сэв суулгах амлалтаа Засгийн газар болих хэрэгтэй гэв.

МОНГОЛЫН МЭДЭЭ

18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч: Ч.ЧУЛУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 88873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба: Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхлэсэн Б.ӨНӨРТОГТОХ

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг: Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот

Харилцах утас, факс: 976-70113551

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

ҮЗЭЛ БОДОЛ

ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН ЯВЦЫГ ГАДНЫХАН ИНГЭЖ ДҮГНЭЖЭЭ

**Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт**

Намуудын мөрийн хөтөлбөр нь тодорхой бус байх бөгөөд ялсны дараах албан тушаал болоод хувийн ашиг сонирхлыг тэд илүүд үзсэн байгаа юм. Үүнийг сонгуулийн сурталчилгаа нь ч улам баталж байх шиг. Тэд өөрсдийн хүсэл эрмэлзлэлээ илүүтэй тайлбарлаж, ерөнхий нөхцөлтэй цөөхөн хэдэн бодлогыг тусгасан байх аж. Гэхдээ яг юуг хэрэгжүүлэх нь үндсэндээ бүрхэг. Үүний оронд нэр дэвшигч нь ямар мэргэжилтэй вэ гэдгийг илүү сурталчилж, харин өрсөлдөгчийнхөө хувийн зан араншинг зэмлэсэн байдалтай. Ардчилсан нам Засгийн газраас уул уурхайн талаарх баримтлах бодлогод итгэхийг иргэддээ уриалж байхад, МАН эсрэгээрээ Монгол Улсын нийт өрийн тухай ярьж явна. Сүүлийн үед гарсан хамгийн том сурталчилгаа нь Таван толгойн хувьцааг Засгийн газар эргүүлэн худалдан авах асуудал байв. Энэ бол “Сайн уу сонгогчид оо. Бид танд мөнгө өгье” гэсэн популист үзлийн хамгийн тод жишээ байлаа. Энэ мэт баталгаагүй улс төрийн бодлого сонгогчдод эргэлзээ төрүүлж байна” гэж бичсэн байна. Мөн “Хар ба саарал пиар” гэх хэсэгт эмэгтэй гишүүдийн квотын тухай өөрийн байр сууриа илэрхийлсэн байв. “Хамгийн их шуугиан тарьж, мэтгэлцсэн сэдэв нь нэр дэвшигч Л.Эрдэнэчимэг тамхи татаж, согтуурхсан бичлэг байв. Энэ мэтгэлцээний хэмжүүр нь үүндээ харамсал төрүүлэхээр. Эмэгтэй гишүүдийн нэг байсан учраас түүнийг архи ууж тамхи татсанаар нь түлхэж буй нь тэр. Эмэгтэй нэр дэвшигчдийг улс төрийн намууд илэрхий хүлээн авахгүй байна. МАН нэр дэвшигчдийнхээ 20 хувьд эмэгтэй хүн нэр дэвшигчдийн хэмээн албан ёсны твиттертэй жиргэсэн байсан ч, тэдний дунд эмэгтэйчүүд бараг харагдахгүй байна...” хэмээжээ.

Сонгогчид улс төрийн хүчинд итгэхгүй байна

“www.pnp.ru” сайтнаа сэтгүүлч

МЭДЭЭЛЛИЙН ЦАГ

Л.Пүрэвсүрэн: Тамхи нэвтрүүлсэн дипломатч тэтгэвэрт гарчихсан, мөн хуурамч наалт наасан байсан



Тэрэл зурвиги I АРГУУЖИЙН

Б.ТОГТОХ

Долоо хоног бүрийн мягмар гарагт болдог Гадаад хэргийн яамны “Мэдээллийн цаг” хэвлэлийн бага хурал өчигдөр боллоо. Хуралд Гадаад хэргийн сайд Л.Пүрэвсүрэн оролцож өнгөрсөн долоо хоногт болсон гадаад харилцааны онцлох асуудлаар мэдээлэл өгсөн юм. Тэрбээр, хуралдааны эхэнд хоёр өдөр болж өнгөрсөн АСЕМ-ын хүнсний салбар хуралдаан болон Ерөнхийлөгчийн Мьянмарын холбооны Бүгд найрамдах улсад хийсэн айлчлалын талаар мэдээлэл өглөө. АСЕМ-ын дээд хэмжээний уулзалт ирэх долдугаар сарын 15, 16-нд болох учиртай. Тэгвэл энэ удаа дагалдах хурлыг Монгол Улс амжилттай зохион байгуулжээ. Одоо таван удаагийн хуралд үлдээд байгаа аж. Ерөнхийлөгчийн айлчлалын тухайд гэвэл, Ерөнхийлөгч Мьянмарын Нэйпидо хотноо зохион байгуулсан “Байгалийн менежмент 2” семинар болон Монгол, Мьянмарын бизнес уулзалтад тус тус оролцсон аж. Бизнес уулзалт нь хоёр орны хөрөнгө оруулалт, бизнесийн орчинг харилцан судлах, бизнес эрхлэгчдийг холбох, монголын компануудад шинэ зах зээл нээх зэрэг чухал ач холбогдолтой байжээ. Ерөнхийлөгчийн хувьд ардчилалын замаар явсан

26 жилийнхээ туршлагаасаа хуваалцаж, 1.800 гаруй төрийн албан хаагчид лекц уншин, төв телевизэд нь ярилцлага өгсөн байна. Түүнчлэн, өнгөрсөн долоо хоногт БНХАУ-д Монгол, Орос, Хятад гурван талын Гадаад хэргийн дэд сайд нарын уулзалт болсон талаар онцлов. Уг уулзалтад ГХЯ-ны ТНБД Д.Ганхуяг оролцоод иржээ. Энэ удаагийн уулзалтаар зургадугаар сарын 23-нд Ташкентад болох гурав дахь удаагийн Монгол, Орос, Хятадын дээд хэмжээний уулзалтын бэлтгэл ажлын талаар ярилцсан байна. Тус дээд хэмжээний уулзалтад оролцохоор Ерөнхийлөгч өнөөдөр өглөө Ташкентыг зорино. Зургадугаар сарын 23, 24-нд зохион байгуулагдах Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын уулзалтын үеэр гурван тал дээд хэмжээний гурав дахь уулзалтаа хийхээр төлөвлөж байгаа юм. Энэ үеэр гурван баримт бичигт гарын үсэг зурахаар тохиролцоод байгаа. Мөн Ерөнхийлөгч Орос, Хятадын талтай хоёр талын уулзалт хийхээр төлөвлөдөг байгааг Л.Пүрэвсүрэн сайд онцолсон юм. Мөн энэ долоо хоногт монголын дипломатч Украинны хилээр их хэмжээний тамхи авч гарах гэж байгаад баригдсан тухай мэдээлэл цацагдсан. Монгол Улсын нэр хүндтэй холбоотой, цаашлаад хоёр улсын гадаад харилцаанд сөв суулгах энэхүү

ноцтой асуудалд Л.Пүрэвсүрэн сайд тайлбар хийлээ. Тэрбээр, “Өнгөрсөн долоо хоногт Монгол Улсын хоёр иргэн Москва дахь ЭСЯ-ны дипломат дугаартай машин ашиглан тамхины наймаа хийх гэж оролдсон талаар мэдээлэл хэвлэлээр цацагдсан. Бид энэ талаар холбогдох байгууллагуудаар дамжуулан тодруулж байна. Энэ асуудалд Будапешт дахь Элчин сайдын яаманд нарийн бичгийн дарга, зөвлөхөөр ажиллаж байсан Д.Дөхөмбаяр холбогдсон тухай мэдээлэл хүлээн аваад байна. Д.Дөхөмбаяр нь Хуудалдааны яамны харьяа “Техникимпорт”, “Монголимпекс” нэгдэлд ажиллаж байгаад 2004-2007 онд

ХӨНДӨХ СЭДЭВ

ДАГУУЛ ХОТУУДЫГ “ДАГАВАР ХҮҮХЭД” МЭТ БОЛГОСОН ТҮҮХ

**Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт**

Уг нь ганцхан жилийн өмнө дагуул хотод хөгжил ирлээ хэмээн суртал ухуулга хийж явсан нөхөд өнөөдөр дагуул хотын оршин суугчдын эрх ашиг ноцтой зөрчигдөж байхад хувь заяанд нь даатгаад чимээгүй орхичихлоо. Ямар сайндаа л энэ хоёр дагуул хотын оршин суугчид, сонгогч олон нэгдэж “Эрх баригчдыг бүү сонго” хөдөлгөөн байгуулсан нь зүй ёсны хэрэг юм.

Өмнөх сонгуулиудаар Налайх дүүргийнхэн Баянзүрхэд, Багануур, Багахангайнхан Хан-Уулын хаяаг түшиж саналаа өгч ирсэн. Тэр үед Налайх, Багануур бол дүүргийн статустай, хөгжлийн бодлого, концепци нь ижил байсан. Харин аж үйлдвэрийн ууган голомт, нэгэн цагт улсын нүүр царай болж явсан Налайхын уурхай, нийслэлчүүдийг илч гэрлээр хангадаг Багануур дүүрэг өнөөдөр дагуул хот хэмээх статустай, хөгжлийн зам, бодлого чиглэл нь дүүргээс огт өөр болсон. Дагуул хотын хөгжлийн чиг хандлагаар бие даан хөгжих боломж бололцоо нь нээгдсэн.

Будапешт дахь Элчин сайдын яаманд анх томилогдон ажиллаж байсан бөгөөд 2011-2015 онд тус улсад дахин томилогдон ажиллаж байгаад 2015 оны наймдугаар сараас өндөр насны тэтгэвэрт өөрийн хүсэлтээр гарсан. Одоогоор хүлээн аваад байгаа мэдээллээр түүнтэй хамт явсан иргэний Гадаад Хэргийн Яам болон аль нэг Дипломат төлөөлөгчийн газарт ажилладаггүй хүн байна. Эдгээр иргэдийн хилээр нэвтрүүлэхийг завдсан ачаанд наасан “дипломат шуудан” гэх наалт нь Монгол Улсын Гадаад хэргийн яам, хилийн чанад дахь аль ч Дипломат төлөөлөгчийн газарт хэрэглэгддэггүй, хуурамч болохыг тогтоосон. Сүүлийн 2-3

жилд бидний зүгээс энэ төрлийн гэмт хэргийн эсрэг олон арга хэмжээ авсны үр дүнд ниймэрхүү хэрэг гараагүй байсан. Энд нэг зүйлийг тодотгоод хэлэхэд манай яамны үндсэн дипломатууд нийм хэрэгт төдийлөн холбогдоод байдаггүй. “Хилээр хийн буу гаргалаа, визний наймаа хийлээ” гэх тохиолдлуудад ихэнх нь үндсэн дипломатууд биш байдаг. Гадаад улсад суугаа ЭСЯ, Конулын газруудад зөвхөн манай яамнаас хүмүүс ажилладаггүй. Бусад яам, газруудаас томилогдон очсон хүмүүс хэрэгт холбогдох нь их байдаг. Ингээд муу үнрийг нь ГХЯ-ны үндсэн дипломатууд үүрдэг” хэмээн бухимдлаа.

Гэвч УИХ-ын сонгуулийн тойргийн хуваарилалтаар энэ бүх боломж нь хязгаарлагдмал болж байна. Багануур дүүрэг гэхэд хороо хорооноос төрсөн дөрвөн гишүүнтэй болно. Дөрвөн гишүүн Багануур хотыг бүхэлд нь гэхээсээ жалга довны үзлээр зөвхөн сонгогдсон хороогоо “бөөцийлөх” байдалар хандах нь тодорхой. Дагуул хотыг хөгжүүлэх нэгдсэн бодлого, зорилт үүндээ цаасан дээр л үлдэнэ. Уг нь дагуул хотын дайтай хөгжүүлэе гэж анхнаасаа зорьсон бол Налайх, Багануур хотыг Багахангай дүүргэнтэй хамтад нь сонгуулийн нэг тойрог болгох хэрэгтэй байв. Үүний төлөө хотын удирдлагууд санаачилга гаргах үүрэгтэй байлаа. Даанч хотын удирдлагууд ч идэвх чармайлт, хүчин зүтгэл гаргасангүй. Алслагдсан энэ гурван суурин газрыг нэг тойрог болгох Сонгуулийн ерөнхий хорооны анхны саналыг шууд бэллүүрдэж байхад дагуул хотыг “эх барьж” авсан Улаанбаатар хотын удирдлагууд огтхон ч эсэргүүцээгүй нь хачирхалтай. Дагуул хотуудыг “дайвар” байдлаар хөгжүүлэх юм бол хот гэж том нэр хайрласны ач холбогдол, үр дүн төдийлөн гарахгүй нь.

Гэвч УИХ-ын сонгуулийн тойргийн хуваарилалтаар энэ бүх боломж нь хязгаарлагдмал болж байна. Багануур дүүрэг гэхэд хороо хорооноос төрсөн дөрвөн гишүүнтэй болно. Дөрвөн гишүүн Багануур хотыг бүхэлд нь гэхээсээ жалга довны үзлээр зөвхөн сонгогдсон хороогоо “бөөцийлөх” байдалар хандах нь тодорхой. Дагуул хотыг хөгжүүлэх нэгдсэн бодлого, зорилт үүндээ цаасан дээр л үлдэнэ. Уг нь дагуул хотын дайтай хөгжүүлэе гэж анхнаасаа зорьсон бол Налайх, Багануур хотыг Багахангай дүүргэнтэй хамтад нь сонгуулийн нэг тойрог болгох хэрэгтэй байв. Үүний төлөө хотын удирдлагууд санаачилга гаргах үүрэгтэй байлаа. Даанч хотын удирдлагууд ч идэвх чармайлт, хүчин зүтгэл гаргасангүй. Алслагдсан энэ гурван суурин газрыг нэг тойрог болгох Сонгуулийн ерөнхий хорооны анхны саналыг шууд бэллүүрдэж байхад дагуул хотыг “эх барьж” авсан Улаанбаатар хотын удирдлагууд огтхон ч эсэргүүцээгүй нь хачирхалтай. Дагуул хотуудыг “дайвар” байдлаар хөгжүүлэх юм бол хот гэж том нэр хайрласны ач холбогдол, үр дүн төдийлөн гарахгүй нь.

Дугаарын **60** мөр

Аялал эхэллээ, амрагчдаа угтахад бэлэн үү

**Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт**

Ээлжийн ажилтай, төрийн албан хаагчдыг эс тооцвол хөгшин хөвөөгүй л хөдөөг бараадаг нь худлаа биш. Аятайхан амралтын газар, хөдөө байгаа ах дүүгээ бараадаг уламжлалаар ч өнөө жил хөдөөгүүр амрагчид олон байх нь. Нөгөө талаар, долдугаар сард Монгол Улсад томоохон дээд хэмжээний уулзалт товлосон. Тэр ч утгаараа нийслэлд аль болох түгжирч бухимдалгүй хөдөө гадаа явж амрахыг төр засгийн удирдлагууд иргэддээ уриалж буй юм. Монгол Улсын нэр хүнд дэлхийд гарах хойно мэдээж уриалгыг нь дагаад хөдөө явах бодолтой хүн олон бий. Гэвч хаана очиж амрах вэ гэдэг нь толгойн өвчин болчихоод байгаа юм. Чин үнэнийг хэлэхэд нийслэлчүүд Горхи-Тэрэлжийн цөөн хэдэн амралтаас үндсэндээ залчихсан. Хүүхэд, хөгшигдгүй ус бараадахгүй хүсч Туулаа даган өсгөдөг ч тухалж амарчихмаар амралтын газар цөөхөн гээд хэлчихээд хатуудахгүй. Мэдээж ам болгонд гэр барьчихсан, амралт байгуулчихсан байхад юу бичээд байна вэ хэмээн бухимдах нэгэн гарч мэдэх юм. Гэхдээ эдгээр амралтын газруудаас аятайхан хоночихмоор газар байдаг билүү хэмээн асуумаар санагддагийг нуух юун. Хүүхэдээ тоглуулчих тоглоомын талаар яриад ч хэрэггүй. Эгнүүлж барьсан хэдэн гэрээс нь архи тамхины нэхүүн үнэр, ор хөнглийнх нь даавуунаас толгой эргэж огиудас хүрэм өмхий үнэр л ханхалж байдгийг худлаа гэж хэлэх хүн гарахгүй биз. Тэрэлжийн орчимд 100 гаруй амралтын газар байлаа гэж бодоход тэндээс стандартын шаардлага хангасан нь гарын 10 хуруунд багтам цөөхөн байдаг. Амралт, аялалын газрын стандартыг хангасан газар нийслэл ч гэлтгүй хөдөө орон нутагт ч цөөхөн. Тиймээс амралт эхэлчихлээ амрагчдаа угтаж авахад бэлэн үү хэмээн асуугаад байгаа юм. Амралтын газрын стандартыг шалгаж хянадаг газрууд ч өнөө жил ажлаа хийсэн шиг хийхгүй бол АСЕМ-ын уулзалтаас “дүрвэсэн” иргэд, цаашлаад том уулзалтын хүрээнд ирэх зочид төлөөлөгч, монголыг зорих жуулчдын тоо энэ зуныг дуустал үргэлжлэх нь тодорхой байгаа юм.

Зарим бэлтгэл зочид мэдээж гэр бүл үр хүүхдээ дагуулаад эрхийг үгүйсгэх аргагүй. Хаа хол Хөвсгөлийн тайга руу зорьж чадахгүй ч хажууханд байгаа Тэрэлж рүү гараад давхилаа гэхэд халтайсан гэртэй, бие засах жорлонгүй утвал юу болох билээ. Тиймээс өнөө жил баталсан журам дүрмээ хэрэгжүүлсэн шиг хэрэгжүүлж хэрэгтэй, хэрэггүй амралтын газруудыг журамлах шаардлагатай байна. Нийтийн бие засах газартай, нойлын өрөөний стандартыг ч ядаахад мөрдүүлдэг болмоор байгаа юм. Ор дэрний цагаан хэрэглэл, барьсан гэрнээс нь эхлээд шахаж шаардах зүйл бишгүй олон гарна. Ганцхан нийслэл ч гэлтгүй хөдөө орон нутгийн удирдлагууд ч амралтын газар ажиллуулж буй иргэддээ зохих ёсны шаардлага тавихгүй бол хөдөөг зорьсон иргэд халдварт өвчин тусчихаад ирэх вий дээ. Өнөө жил нийт нутгаар хур бороо элбэг байхыг Цаг уур орчны шинжилгээний хүрээлэнгээс анхааруулж байна. Тиймдээ ч амралтаар хөдөө явсан иргэд майхан саваа барих гэхээс илүү амралтын газар бараадах нь тодорхой байгаа юм. Харин тэднийг үгүйсгэхгүй амралтад буулгачихаад мөнгийг нь “сааж” байвал хэн юу хэлэх билээ. Чийгтэй гэр байшин, тохь тухгүй амралтад угтчихаад тэнгэрт тулсан үнэ хэлээд суувал хэн ч үйлчилүүлэхгүй гэдгийг эрхэм бизнес эрхлэгчид тунгааж нэг бодох биз.



Необычная избирательная кампания певца Жавхланы. ФОТО



Необычная избирательная кампания певца Жавхланы. ФОТО

ХАРЬЦУУЛСАН СУРВАЛЖЛАГА

Үнэ дагаж үйлчилгээ гэдгийг



–Эко цэцэрлэгт хүрээлэн хар зах болж хувирчээ–

Төгсгөл. Түрүүч нь I нүүрт

Гэхдээдгээр хоёр газрын үнэ төлбөр, цаашлаад үйлчилгээний соёлыг харьцуулахыг чухалчилсан юм.

Нарантуул уу, Цэцэрлэгт хүрээлэн үү

Ойр хавьд ямар ч гарц алга. Зорьсон газраа хүрэхийн тулд гарцгүй газраар зам гарах шаардлагатай. Зүүн гар талаас машины тойрог урсгал орж ирж байгаа учраас нэлээд анхаарал, болгоомжтой байхгүй бол хүүхэд байтугай том хүн ч бэртэж гэмтэх, цаашлаад амь насаа алдах эрсдэлтэй юм билээ. Хүмүүс гарц байхгүй учраас шууд л зам хөндлөн гарч харгадлаа. Машины урсгал саарахыг хүлээж таван минут саатсаны эцэст зорилготой газраа ирлээ. Хаалгаар нь ормогц л шорлогны үнэр хамар сэтгэлж, хаа нэг утаа сүүмэлзэн, энд тэндгүй “Хоёр мянгаар 12 сум шидээд тоглоом аварай”, “Зургаан сум шидээд оновол 10 мянган төгрөг ав, онохгүй бол зургаан мянган төгрөг ав”, “Хүүхдийн тоглоом зарж байна”, “Хөөсөн чихэр аварай, амттай шүү” гэх дуу хадгаж, хажуугаар өнгөрсөн нэгнийг барьж авах нь холгүй авирлах худалдагчид, төв хаалганаас эхлэн намхан тавиур дээр өрсөн нүд эрээлжлэм, өнгө өнгийн тоглоомууд харгадлав. Нарантуул зах руу ороод ирчих вүү гэж андуурмаар энэ газар бол нийслэлчүүдийн амралт, чөлөөт цагаа өнгөрүүлдэг Үндэсний цэцэрлэгт хүрээлэн. Тус хүрээлэн нь анх 2010 онд НИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын 30 дугаар тогтоолоор байгуулагдаж байсан. Өдгөө 110 гаруй ажилчинтайгаар үйл ажиллагаагаа явуулж байгаа аж. Нийслэлийн иргэдийн амралт чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх орчин үеийн тохилог орчинг бий болгохоор зорьж буй Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн зорилт, зохион байгуулалт хоёр зөрж байна уу гэлтэй. Зах замбараагүй худалдаа, үйлчилгээний зохион байгуулалтад бухимдах хүмүүс ч цөөнгүй байлаа.

Энэ талаар иргэн Т.Баяраа “Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд гэр бүлээрээ ирэх дуртай. Орой ажлаа тараад хүүхдүүдээ, эхнэрээ аваад ирэх сайхан байдаг. Гэхдээ сүүлийн үед Үндэсний цэцэрлэгт хүрээлэн их бохир болсон. Хаа сайгүй л шорлог зарж орилсон хүмүүс. Өнөөдөр арай гайгүй байна. Та нар хүүхдийн баяраар энд ирсэн бол ямар байсныг нь мэдэж байгаа байлгүй. Юунхүүхдүүдээ баярлуулах бухимдсаар байгаад таарсан. Хэдэн хуушуур, шорлог идээд, усан завинд хүүхдүүдээ суулгаад л явсан. Ямар ч зохион байгуулалтгүй. Энд тэнд зарж байгаа хятад тоглоомуудыг хүүхэд хараад авна гэнэ. Авч өгөхгүй байх хэцүү. Аваад өгье гэхээр үнэтэй байдаг. Залуу гэр бүлүүдэд хэцүү л дээ. Үүд хэсгээрээ хөл хөдөлгөөн ихтэй. Энд тэндгүй юм ав гэж орилсон хүмүүс байдаг юм. Харин усан

оргилуураас цаашаа арай гайгүй. Чимээ шуугиан ч намдаад ирдэг. Сүүлийн үед цэцэрлэгт хүрээлэнд дугуй унах гэж л ирдэг болсон. Манай хүү дөрвөн настай юм. Энэ жил дугуй унаж сурсан. Тиймээс орой болгон ирж байна. Ер нь цэцэрлэгт хүрээлэнг зорих хүмүүсийн тоо эрс ихэссэн. Зарим газар хүмүүс нь хэт бөөгнөрөөд суух сандалгүй болчихно. Хүмүүсийн тоо ихэсч байгаа учраас цэцэрлэгт хүрээлэнгээ зохион байгуулалттай, эмх цэгцтэй болгох хэрэгтэй байх. Ядаж л бараа зарж байгаа хүмүүсээ цэгцэлчих хэрэгтэй шүү дээ.

Энэ чинь нийслэлд байгаа ганц л ногоон цэцэрлэг шүү дээ. Бид хүрээлэнд ирэх дуртай” гэсэн юм. Манай сурвалжлах хэсэгтэй цэцэрлэгт хүрээлэнд дугуй унах гэж л ирдэг гэсэн залуус цөөнгүй таарсныг нуух юун. Магадгүй тус хүрээлэнд байрлах “Green bike” дугуй түрээсийн газарт очиход л хүмүүс ямар зорилгоор ирдэг болсныг мэдэж болно. Найзуудтайгаа хамт дугуй унахаар ирсэн гэх охиныг Б.Мичидмаа гэдэг. Тэрбээр, “Би найзуудтайгаа хамт дугуй унахаар цэцэрлэгт хүрээлэнд ирдэг. Дугуй унах сайхан байдаг юм. Өмнө нь цэцэрлэгт хүрээлэн цэвэрхэн, тайван байсан. Одоо хүмүүс их ирдэг болсон болохоор эмх замбараагүй болсон. Энд янз бүрийн тоглоом байдаг. Бид тэр сум шиддэг тоглоомыг тоглодоггүй. Хий дэмий мөнгө үрсэн зүйл. Хиртэй чихмэл авах гэж 2000 төгрөг төлсний оронд дугуй аваад хүрээлэнг



нэг бүтэн тойрсон нь дээр. Дугуйнаас бусад үйлчилгээ нь нэг их таалагддаггүй” хэмээсээр найзуудтайгаа дугуйгаа унан явцгаалаа. Уг нь Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд хүмүүс зөвхөн дугуй унах гэж биш гэр бүлээрээ алхаж, хүүхдүүдтэйгээ тоглож, цагийг зугаатай өнгөрөөх гэж ирэх ёстой. Гэвч эмх замбараагүй зохион байгуулалтаас хар зах шинг уур амьсгал үүсчээ.

Хогийн савтайгаа зэрэгцсэн хоолны буфетуудыг хэрхэх вэ

Оройн 20.30 цаг гэхэд Маршалын гүүрнээс Баянзүрхийн гүүр хүртэлх,



Туул голын дагуу 960 га талбайд баригдах Үндэсний цэцэрлэгт хүрээлэнг зорих хүмүүсийн тоо тасрахгүй байлаа. Хүрээлэнг зорьж ирсэн хүмүүс эндээс хоол авч, идэхгүйгээр гарах нь ховор аж. Орж ирсэн хүн бүр л төв хаалганаас урагш байрласан хоолны буфетуудад дугаарлан зогсоцгоож харгадсан. Зарим нэг нь ширээ, сандал байхгүйгээс нэгнийгээ босохыг хүлээж байв. Урд талдаа тус бүр дөрвөн сандалтай гурван ширээ байрлуулсан буфетуудын хоолны цэсний сонголт нь тун ядмаг. Ихэвчлэн бэлэн бүтээгдэхүүн. Эндээс бэлэн хайрсан хуушуур, хотдог, шарсан тахианы мөч, бургер л авах боломжтой бөгөөд 1000-3500 төгрөгийн үнэтэй. Хоолны

ширээтэй зэрэгцээд халтаргаж, хог нь халхаа дөхсөн хогийн савнууд байрласан харгадана. Хогийн савыг харсан зарим нь ярвайж, нөгөө хэсэг нь ширээгээ солин сууна. Тус хүрээлэнд зарагдаж байгаа хоолны чанарт хяналт тавьж байгаа эсэхэд эргэлзээр. Бүхээгтэй портер машинтай хүмүүс тус хүрээлэнд ирсэн иргэдэд хуушуур зарж байх юм. Хоолны эрүүл ахуй гэдэг чухал. Ялангуяа хүн ихтэй, хүүхэд багачууд ихээр цугларсан газруудын хоолны чанар, хоол хийх, зарах байрны эрүүл ахуйн шаардлага нэн тэргүүнд тавигдах ёстой. Гэвч энд тийм зүйл алга. Бид төв хаалганаас гадна зүүн талын хаалгаар дахин орж үзлээ. Зүүн талын хаалганы гадна талд

City toilet байрлах бөгөөд 200 төгрөгийн үнэтэй. Тус арнун цэврийн газар дотор ундаа, ус зарж харгадсан. Харин хаалганы үүдэнд машины зогсоолын мөнгө хураах цэг байрлажээ. Хүрээлэнгийн зогсоолд машинаа байрлуулахын тулд 30 минут 500, 31-60 минут 1000, 81-120 минутын үнэтэй. Хэрвээ цагаасаа хэтэрвэл 3000 төгрөгийн торгуультай юм билээ.

...Орж ирсэн хүн бүр л төв хаалганаас урагш байрласан хоолны буфетуудад дугаарлан зогсоцгоож харгадсан. Зарим нэг нь ширээ, сандал байхгүйгээс нэгнийгээ босохыг хүлээж байв. Урд талдаа тус бүр дөрвөн сандалтай гурван ширээ байрлуулсан буфетуудын хоолны цэсний сонголт нь тун ядмаг. Ихэвчлэн бэлэн бүтээгдэхүүн. Эндээс бэлэн хайрсан хуушуур, хотдог, шарсан тахианы мөч, бургер л авах боломжтой бөгөөд 1000-3500 төгрөгийн үнэтэй...

3000 төгрөгийн аюул дагуулсан тоглоомууд

Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд байрлах “Чонын элч” хөшөөний урд талд хүүхдийн тоглоомын хэсэг байрлана. Тус хэсэгт хийлсэн гулсуур, усан завь, морин тойруулга, савлуур, байт харваа гээд төрөл бүрийн тоглоом байрлах аж. Тоглоом тус бүрийн үнэ 3000-5000

төгрөгийн үнэтэй. Тодруулбал, хүүхэд өөрөө сэлүүрддэг жижиг усан завь, морин тойруулга таван минут нь 3000, байт харваа таван сум нь 3000, 10 сум 5000 төгрөгийн үнэтэй байлаа. Харин хийлдэг гулсуур 3000 төгрөгийн үнэтэй бөгөөд хэдэн ч цаг тоглох боломжтой. Энд байгаа тоглоомуудын ганц цагаар хэмжигддэггүй тоглоом нь хийлсэн гулсуур. Гэвч аюулгүйн баталгаа алга. Хийлсэн гулсуур нь бараг орон сууцны нэг давхартай тэнцэхээр өндөртэй. Гулсуурыг тойруулан хамгаалалтын ямар нэгэн бэхлэлтгүй. Харин зүүн доод талд нь жижиг цахилгаан мотор хүнгэнэн дугаарч харгадсан. Гулсуур дээр тоглож байгаа хүүхдүүд мотор нь дээр унаж мэдэхээр. Мөн хүүхдийн тоглоомын хэсэгт зам тавиагүйгээс тоос босч, хүүхдүүдийн хувцас халтар болсон байв. Ийм орчинд хүүхдүүд тоглож байлаа. Хүүхдийн тоглоомын хэсгийн зүүн талд “Green bike” дугуй түрээсийн газар байрладаг. Түрээсийн үнэ дугуйны хэмжээнээс хамаарч харилцан адилгүй. Дөрвөн хүний саравчтай дугуй 7000, хоёр хүний 5000, цуваа дугуй 3000, нэг хүний дугуй 2000 төгрөгөөр түрээслэх боломжтой байна. Тус хүрээлэнд хөл бөмбөг, сагсан бөмбөг, агаарын теннисний талбай байх бөгөөд эдгээр талбайд үнэгүй тоглож болно.

Энэ янзаараа зүлэг ч үгүй болох нь...

Энд дуртай хүн бүр зүлгэн дээгүүр гүйж, дугуйтай явж тоглоно. Зарим хэсгээр хүн их явснаас болж зүлэг нь халцарч шороон зам гарчээ. Зүлгэн дээгүүр хүн явж байгаад санаа тавих хүн гэж алга. Хүссэн газартаа хүмүүс товчилж хүрч байх юм. Энэ талаар иргэдийн санаа бодлыг сонсоход иргэн н.Сарангэрэл “Хүмүүс ухамсаргүй байна. Нийслэлдээ ийм сайхан цэцэрлэгт хүрээлэнтэй болж байхад хайрлаж хамгаалж чадахгүй байна. Хэрвээ энэ янзаараа хандвал зүлэггүй л болно шүү дээ” хэмээн ярих нэгэн байхад “Цэцэрлэгт хүрээлэнгийн зам толгой эргэмээр. Нэг замаар явахаар өөр тийшээ аваад оччихно. Тэр нь настай хүмүүс хэцүү л дээ. Тэгээд л

MMINFO.

Тал нутгийн цахим мэдээлэл



ХАРЬЦУУЛСАН СУРВАЛЖЛАГА



хэмнэх боломжийг ч бас паркийн хамт олон олгожээ. Тухайлбал, “Super” багц 25 мянган төгрөгөөр аваад арван тоглоом, 20 мянган төгрөгийн үнэтэй “COOL” багцаар долоон тоглоом, “Harry” багцыг 15 мянгаар авч, таван тоглоом, “Fun” багц 10 мянга төгрөгөөр аваад гурван тоглоомоор тоглох боломжтой байна. Багц бүрт орох тасалбарын 1000 төгрөг багтсан гэнэ. Тус хүрээлэн үйлчлүүлэгчдээсээ хураасан орох тасалбарын 1000 төгрөгийг автомашины зогсоол, зорилгот бүлгийн хүүхдүүдийг зохион байгуулалттайгаар үнэ төлбөргүй тоглуулах, болон төлбөргүй тоглоомуудад зарцуулдаг гэнэ.

Мөн хоолны газраар үйлчлүүлсэн үнийн дүнгээс 1000 төгрөгөөр хөнгөлөх, ногоон байгууламж, өдөр тутмын хөтөлбөр, цэвэр цэмцгэр орчны тохижилт, аюулгүй байдал зэрэгт зарцуулдаг. Үндэсний соёл, амралтын хүрээлэнд байрлах “Sport pub” залуусын очих дуртай газрын нэг болжээ. Тус паб нь орчин үеийн интерьерийн өвөрмөц шийдэлтэй, 120 хүний суудалтай бөгөөд бүх төрлийн спортыг шууд дамжуулдаг байна. Мөн олон төрлийн уралдаан тэмцээнийг тогтмол явуулдаг аж. Wii, PS3, XBOX зэрэг өнгөний ялгарал болон дуу авианы эффект сайтай, өргөн дэлгэц дээр хамгийн сүүлийн үеийн тоглоомуудыг тоглох боломжтой. Мөн өөрт болон хайртай гэр бүлдээ тохиож буй тэмдэглэлт баярын өдрүүдээ хэзээ ч мартагдашгүй өнгөрөөхийн тэмдэглэлт өнгөрөөхийн хүсвэл “Төрсөн өдрийн үйлчилгээ”-г авч

ертөнц” тоглоомын төвийг ажиллуулдаг. Булан тохой бүрт хогийн сав байрлуулж, цэвэр цэмцгэр орчныг төгс бүрдүүлж чадсан энэ газарт хүмүүс ч соёлтой үйлчлүүлж байсан юм. Үйлчилгээний чанарт ч сэтгэл хангалуун байгаагаа иргэд хэлж байлаа. Иргэн Б.Наранчимэг “Манай улсад байгаа цорын ганц хүүхдүүдэд зориулсан томоохон хэмжээний тоглоомын газар бол парк. Бид хүүхдүүдтэйгээ хааяа паркт ирэх дуртай. Заримдаа хөдөөнөөс ах дүүсийн маань хүүхдүүд ирвэл бас энд авч ирдэг юм. Паркийн тоглоомууд харьцангуй хүүхдийн аюулгүй байдлыг хангасан байдаг. Мэдээж хүүхдүүдээ насанд нь тохирсон тоглоомонд суулгах хэрэгтэй. Зарим нэг хүүхэд суухад аюултай тоглоомууд харагддаг. Гэхдээ суулгадаггүй” гэсэн юм. Баярнаадмын үеэр дараалал нь дийлдэхгүй хонох шахан байж тоглодог гэж бухимдаж байсан иргэд өнөөдөр тайван ярах зүйлгүй, ээлжээ хүлээнгээ бусдаасаа туршлага судлаж байв. Гэвч сайны хажуугаар саар гэгчээр архи гэгч гашуун ундаа ч мөн энд байсаар л байна. Хаа сайгүй баар цэнгээний газрууд үйл ажиллагаа явуулж согтууруулах ундаа худалдагчийн жишгээр энд ч бас тодорхой хэдэн газарт зарж байсан юм. Бусад газрын үнэтэй харьцуулахад хамаагүй үнэтэй. Өсвөр насны охид хөвгүүд маш ихээр согтууруулах ундаа эрхэлэн, тамхи татаж хоорт муу зуршилтай болж байгаа нь үнэхээр сэтгэл эмзэглүүлэв. Магадгүй согтуу хөлчүүрхэж явахдаа хэн нэгнийг гэмтээх, айлгаж цочоох зэрэг эрсдэл гарахгүй гэх зүйлгүй.

...Үндэсний соёл, амралтын хүрээлэнд ганц нэг засах зүйл байгаа ч авах зүйл их байна. Ядаж л энд хүмүүс хогоо хогийн савандаа хийж хэвшчээ. Харин Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн хувьд хар захаас дутахгүй болсон гэхэд хилсдэхгүй. Эмх замбараагүй байрласан худалдаа үйлчилгээ нь хүмүүсийг залхааж эхэлсэн. Машин бүрээс авсан зогсоолын мөнгөөр парк шиг зорилгот бүлгийн хүүхдүүдэд зориулахгүй юм гэхэд хүрээлэнд худалдаа эрхэлж байгаа хүмүүсээ зохицуулах арга хэмжээ авбал зүгээрэн.

“Супер багц” 25 мянган төгрөгийн үнэтэй

Манай сурвалжлах хэсгийн очсон бас нэгэн газар бол Үндэсний соёл амралтын хүрээлэн буюу бидний хэлж заншсанаар парк. Энэхүү газар анх 1965 оны арваннэгдүгээр сарын 10-нд Улаанбаатар хотын хүүхэд, залуучуудын дунд соёл хүмүүжлийн ажлыг өргөн зохион, тэдний чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөж байх зорилгоор “Хотын Соёл Амралтын Парк” нэртэйгээр байгуулагдсан түүхтэй аж. Хүүхдийн парк нь 35 га дэвсгэр нутагтай, үүнээс 25 га талбайг нь ногоон байгууламж, 1.8 га газрыг нуур цөөрөм, 5.6 га нь тоглоом тоног төхөөрөмж, соёлын төвүүдийн болон аж ахуйн зориулалттайгаар баригджээ. Парк гадна талаасаа эхлээд л эмх цэгцтэй харагдаж байлаа. Үүднээсээ эхлэн паркийг зорин ирсэн хүмүүсийн авто машинууд цэгцтэй, хэн хэндээ саад болохооргүй эгнээ байраа эзэлжээ. Энд цаг минут өнгөрөх тусам машины зогсоолын төлбөр нэмэгдэнэ гэж санаа зовох хэрэггүй юм билээ. Учир нь машины зогсоол нь төлбөргүй. Харин парк руу ороход 1000 төгрөг төлөх шаардлагатай. Мөн Цэцэрлэгт хүрээлэнг бодвол хоолны газрууд тун тухтай. Энд тэнд хөглөрсөн олон түргэн үйлчилгээний цэггүй тодорхой газарт тохилог тухтай хоолны газар, кофе шөф, хүүхдүүдийн хамгийн амтархан иддэг зайрмагны цэгүүд байрлажээ. Харин хүүхдийн тоглоомын хувьд маш үнэтэй. Ёстой л баячуудын хүүхэд парк, борчуудын хүүхэд Цэцэрлэгт хүрээлэнг зорьдог гэх дэгсдүүлсэн яриаг үнэн гэдгийг батлах гэсэн мэт жижиг усан буу 2000 төгрөгөөс эхэлж, 75 мянгад хүрч байв. Үнийн хувьд жирийн супермаркетуудад зарагддаг үнэтэй дүйх боловч дунджаас доош орлоготой айлын хүүхэд үйлчлүүлэх боломж тун бага. Харин тоглоомын хэсэгт нь үлгэрийн баатрууд, амьтны ертөнц, галт тэрэг, алсыг харагч, галзуу хулгана, хийн буудлага, аймшгийн байшин гээд хүүхэд бүрийн сонирхол татахуйц тоглоом олон байлаа. Энд тоглоом бүр өөр өөрийн талбайтай, эмх цэгцтэй. Бүх тоглоомууд 4000-5000 төгрөгийн үнэтэй.

Мөн орох бүртээ 1000 төгрөгийн тасалбар авч орно. Ингэхээр ихэнх хүүхдүүд 2-3 тоглоомыг тоглоод л бусдыг нь харж зогсохоос өөр аргагүй болдог нь илт. Гэхдээ мөнгө

ЗӨВХӨН 6-Р САРД

КОМПЬЮТЕР ХУДАЛДАН АВСАН ХҮН БҮР 9 БЭЛЭГТЭЙ ЭСВЭЛ

БОНУС КАРТ 5% урамшуулалтай

Зөвхөн "DELL Center"-т
Хаяг: Компьютер Ландын зүүн талд DELL Center
Холбогдох утас: 9906-9493, 9904-2031

ДЭЛХИЙ


Барак Обама “ЛинкедИн” сүлжээнээс ажил хайх гэнэ

АНУ-ын Ерөнхийлөгч Барак Обамагийн бүрэн эрхийн хугацаа ирэх оны нэгдүгээр сарын 20-нд дуусч, албан тушаалаасаа буух билээ. Огцорсны дараа Обамагийн нас 55 хүрэх бөгөөд ахимаг насныхны тоонд багтаж эхлэх юм. Тиймээс түүний ямар ажил хийх нь тодорхойгүй байсан. Тэгвэл “SelectUSA” хөрөнгө оруулагч нарын уулзалт дээр Б.Обама үг хэлэхдээ “ЛинкедИн”

нийгмийн сүлжээний сайтын нэрийг дурьдаж, “Долоон сарын дараа би энэ сайтаас ажил хайх болох нь. ЛинкедИн-д бүртгүүлж, юу байгааг нь харна гэж бодохоор сэтгэл догдолж байна шүү” гэж хэлжээ. Үүнээс өмнө ч тэрбээр “ЛинкедИн” сайтад залуу хүмүүст зориулсан хөтөлбөрийн талаарх мэдээллийг байршуулж, өсвөр насандаа хамгийн анх зайрмагны сүлжээ дэлгүүрт

ажиллаж байсан тухайгаа дурссан байдаг. Тодруулбал, энэ оны хоёрдугаар сард “Миний ажил тийм ч сонирхолтой байгаагүй, гэхдээ надад маш үнэтэй сургамж өгсөн. Хариуцлага, хөдөлмөр, найз нөхөд, гэр бүл болон сургууль, ажлынхаа аль алинд нь тэнцвэртэйгээр анхаарах хэрэгтэй юм байна гэдгийг ойлгуулсан юм” гэж бичиж байв.

ДОНАЛД ТРАМП АМИА АЛДАХ ШАХАВ



хүчээ авч байсан удаатай. Улмаар 574 мянган хүн Доналд Трампыг улсын хил нэвтрэхийг хориглох хүсэлтэд гарын үсгээ зурснаар уг асуудлыг Их Британийн төр засгийн хэмжээнд авч хэлэлцэж байв. Гэвч АНУ-тай харилцах харилцаанд сөргөөр нөлөөлж магадгүй гэж үзсэн учир уг асуудлыг хэлэлцэлгүй орхиж байсан билээ. Хэлсэн үгнээсээ болж, үргэлжилж асуудалд орж явдаг шоу бизнесмен эр мусальман шашинтнуудыг АНУ-ын хил рүү нэвтрүүлэхгүй гэж хэлээд британичуудыг дургүйцлийг төрүүлсэн байдаг. Түүнчлэн Европын гол хотуудын нэгд тооцогддог Лондон хотын захирагчийн энэ оны сонгуульд мусальман шашинтайхунялалтбайгуулсан байдаг бөгөөд тэрбээр АНУ-ын Ерөнхийлөгчөөр Доналд Трамп сонгогдсон тохиолдолд тус улс руу зорчихгүй хэмээж байсан удаатай. Доогоор АНУ-ын сонгуульд Ардчилсан намаас Хиллари Клинтон, Бүгд найрамдах намаас Доналд Трамп нар хүч үзэх нь тодорхой болоод буй билээ.

Б.ДАВААХҮҮ

АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд Бүгд найрамдах намаас нэр дэвших нь тодорхой болоод буй үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан Доналд Трампын амь насанд халдахыг завдсан хэрэг гарлаа. Тодруулбал, Невада мужийн Лас Вегас хотод иргэд сонгогчидтойгоо Трампыг уулзалт хийж байх үед нэгэн эр түүний амь насанд нь халдахыг завдан цагдаа нараас бууг нь булааж авахыг оролдсон байна. Их Британи гаралтай 20 настай залуу Майкл Сандфорд уг хэргийг үйлдэхээр

санаархжээ. Хэрэгтэн анхны мэдүүлэгтээ “Доналд Трампыг хөнөөхийн тулд Лас Вегаст ирсэн” гэж ярьсан байна. Түүнийг санаатайгаар бусдын бие мах бодид халдахыг завдсан хэргээр шалгаж буй бөгөөд гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон тохиолдолд хамгийн ихдээ 10 гаруй жил шоронд хоригдох ял, 250 мянган ам.долларын торгууль ногдуулах хуультай гэнэ. Сандфорд биедээ Их Британийн жолооны үнэмлэхийг авч явсан бөгөөд тус бичиг баримтад үндэслэн түүнд хэрэг үүсгэж эхэлсэн байна. Тэрбээр, АНУ-д жил

орчим хугацаанд амьдарч буй аж. Нью Жерси мужийн Хобокен хотод хагас жил орчим амьдарсан залуу энэ сарын 16-нд Лас Вегаст очих хүртлээ Калифорни мужийн Сан Бернардино амьдарч байжээ. АНУ-д байх нэг жилийн хугацаанд залуу Доналд Трампын амийг бүрэлгэхээр бэлтгэж байсан бөгөөд анхны мэдүүлэгтээ “тэр үхэх ёстой” хэмээн ярьсан байгаа юм. Үүнээс гадна бэлтгэлээ ч хангасан байжээ. Тодруулбал, Баттлефилд Вегас гэх буудлагын төвд очиж, есөн мм-ын “Glock” гэх буугаар 20 удаа буудаж,

бэлтгэлээ базаасан гэнэ. Цагдаагийн байгууллагад өгсөн мэдүүлгийн дагуу нэрээ нууцалсан эх сурвалж Санфордын хүн амины хэрэг үйлдэхдээ хэрхэн бэлтгэж байсныг хэвлэлийнхэнд ярьсан байна. Доналд Трампын Лас Вегасын иргэд сонгогчидтой хийх уулзалт казино дотор байрлах “Мистере” театрт болсон бөгөөд 1500 орчим хүн цугларсан байжээ. Дашрамд дурьдахад, энэ оны эхээр Их Британид социал сүлжээгээ Доналд Трампыг тус улсын хилийг нэвтрэхийг хориглох эсэх талаарх санал асуулга

Хятадын супер компьютер анх удаа АНУ-ын “урд гишгэлээ”

Дэлхийн супер компьютер хөгжүүлэлтийн салбарт толгой цохиж буй топ 500 нэгжийн жагсаалтыг зарлалаа. Улмаар АНУ-ын нэг ч технологийг ашигласгүйгээр 100 хувь өөрсдөө бүтээсэн микрочипээ ашиглан бүтээсэн Хятад супер компьютер анх удаагаа тус жагсаалтыг өнгөлжээ. www.top500.org сайтад нийтлэгдсэнээр Хятадын үндэсний үйлдвэрийн “Sunway TaihuLight” гэх компьютер хурдаараа жагсаалтын нэгдүгээрт бичигдсэн байна. Өмнө нь жагсаалтыг АНУ-ын “Интел” компанийн үйлдвэрлэсэн чипийг ашиглаж Хятадад бүтээсэн компьютер тэргүүлж байсан бол энэ удаагийн тус загвараасаа хоёр дахин хурдан гэнэ. Түүнчлэн, дэлхийн Top-500 компьютерын 167 нь Хятадынх бол 165 нь АНУ-ынх байжээ. Ийнхүү тус

жагсаалтад анх удаагаа Хятад улс супер компьютер үйлдвэрлэлээрээ АНУ-ын урд гишгэсэн байна. Манай урд хөршийн Жиансу мужийн Вуши хотод байрлах супер компьютерын улсын үйлдвэрт үйлдвэрлэгдсэн “Sunway TaihuLight” компьютерыг уур амьсгалын хяналт, амьдралын шинжлэх ухааны судалгаанд ашиглахаар төлөвлөж байгаа ажээ. Жилд хоёр удаа гаргадаг Top-500 жагсаалтыг Герман болон АНУ-ын мэргэжилтнүүд харьцуулалт хийх замаар хурдыг нь хэмжиж, түүн дээрээ тулгуурлан гаргадаг шалгаруулдаг байна. Энэ удаагийн жагсаалтын топ 10-т багтсан супер компьютеруудыг улсаар нь ангилвал, Хятадын хоёр, АНУ-ын дөрөв, Япон, Герман, Швейцарь, Саудын Араб зэрэг улсын тус тус нэг компьютер багтжээ.

В.Путин БНХАУ-д айлчилна

ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин БНХАУ-д төрийн айлчлал хийхээр болсон талаар “www.dailymail.co.uk” мэдээллээ. Путин бизнес эрхлэгчдийн хамтаар энэ сарын 25-ны өдөр Бээжин хотноо очиж, тус улсын удирдлагуудтай уулзахаар болсон талаар Кремлийн хэвлэлийн албанаас дамжуулав. БНХАУ-ын Гадаад хэргийн яамны төв сайтад “Си Зиньпин даргын урилгаар Оросын тэргүүн айлчлахаар боллоо” гэж бичжээ. Уг уулзалтаар хоёр тал 50 гаруй хамтран ажиллах

гэрээнд гарын үсэг зурах гэнэ. Си дарга Москва хотноо зохион байгуулагдсан ялалтын 70 жилийн ойн парадьд үзснийхээ дараа Путиныг эх орондоо айлчлахыг уриалсан юм. Бээжин, Москвагай төмөр замын асуудал дээр хамтран ажиллах сонирхолтой байгааг “Синьхуа” агентлаг онцолжээ. Гуанжоу хотноо ирэх есдүгээр сарын 4-5-ны өдрүүдэд “Их 20”-ын уулзалт зохион байгуулагдах юм. Энэхүү уулзалтын дараа Си, Путин болон Обама нар уулзаж, дэлхийн эдийн засгийн асуудлаар ярилцахаар болжээ.

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2016 оны 06 дугаар сарын 21-ний өдөр
Тендер шалгаруулалтын нэр: Цахилгаан дамжуулагч кабель худалдан авах
Тендер шалгаруулалтын дугаар: ИХ-2016/08-012Н

ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР ХХК нь эрх бүхий тендер оролцогчдоос нийлүүлэх Цахилгаан дамжуулагч кабель нийлүүлэхтүхай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг бичгээр хүсэлтээ гаргаж, эргэжтөлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь 50 000 төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерийн баримт бичгийн төлбөрийг Голомт банкны Орхон аймгийн салбар дахь Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн 400 102 2146 тоот дансанд төлсөн байна. Тендер оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 3 жилийн /2013,2014,2015 он/-ийн аль нэг жилийн борлуулалтын хэмжээ нь тендер санал болгож буй үнийн дүнгийн 50

хувиас багагүй байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой эзэлийн хэмжээ: 100 сая төгрөгөөс багагүй байна.

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 3 жил /2013,2014,2015 он/
Тендерийнхамт: 2,119,950 төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2016 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 10 цаг 00 минутас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендер оролцогчдыг байлцуулан тендерийг 2016 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй. Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2016 оны 06 дугаар сарын 21-ний өдөр
Тендер шалгаруулалтын нэр: Химийн урвалжууд худалдан авах
Тендер шалгаруулалтын дугаар: ИХ-2016/14-013

ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР ХХК нь эрх бүхий тендер оролцогчдоос нийлүүлэх Химийн урвалжууд нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна. Тендерийн баримт бичгийг бичгээр хүсэлтээ гаргаж, эргэжтөлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь 50 000 төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерийн баримт бичгийн төлбөрийг Голомт банкны Орхон аймгийн салбар дахь Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн 400 102 2146 тоот дансанд төлсөн байна. Тендер оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 3 жилийн /2013,2014,2015 он/-ийн аль нэг жилийн борлуулалтын хэмжээ нь тендер санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой эзэлийн хэмжээ: 100 сая төгрөгөөс багагүй байна.

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 3 жил /2013,2014,2015 он/

Тендерийн хамт: 941,471 төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2016 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 10 цаг 00 минутас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендер оролцогчдыг байлцуулан тендерийг 2016 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй. Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

ОРХОН АЙМАГ, БАЯН-ӨНДӨР СУМ, НАЙРАМДАЛ ТАЛБАЙ
ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР ХХК-ИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРГААНЫ БАЙР, 347 ТООТ ӨРӨӨ
УТАС:01-352-73371 ФАКС: 01-352-73686 ВЭБ САЙТ: WWW.ERDENETMC.MN
E-MAIL: MYAGMARKHAND@ERDENETMC.MN

ОРХОН АЙМАГ, БАЯН-ӨНДӨР СУМ, НАЙРАМДАЛ ТАЛБАЙ
ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР ХХК-ИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРГААНЫ БАЙР, 347 ТООТ ӨРӨӨ
УТАС:01-352-73371 ФАКС: 01-352-73686 ВЭБ САЙТ: WWW.ERDENETMC.MN
E-MAIL: MYAGMARKHAND@ERDENETMC.MN

ШУУРХАЙ МЭДЭЭ

Цалин нэмэх мөнгөгүй атлаа сонгууль болохоор мөнгө тараалаа гэв

Б.САРНАЙ

Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Хорооноос өчигдөр Төсвийн тодотголтой холбоотой асуудлаар мэдээлэл хийлээ. Хуралд Монголын ажилтан албан хаагчдын холбооны Үйлдвэрчний эвлэлийн дарга М.Алтанцэцэг, БСШУ-ы Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга Ж.Батзориг, Монголын авто замчдын үйлдвэрчний холбооны дарга Б.Цэрэнпүрэв болон бусад албаны хүмүүс оролцлоо. Хурлын үеэр М.Алтанцэцэг “Аливаа төсөл хөтөлбөрийн хэрэгжилт үр дүн дээр Засгийн газар, Үйлдвэрчний эвлэлүүд хяналтаа тавьж байж амжилттай хэрэгждэг. Ялангуяа эргэн төлөгдөх зээлийн асуудал ард түмний нуруун дээр эргээд тодорхой хугацаанд эргэж ирнэ. Жишээлбэл, дулааны үнэ нэмэгдсэн, иргэд энэ төлбөрийг төлж байгаа. Тийм учраас энэ бүх зүйлд хяналт тавих хэрэгтэй. Төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх, 2015 онд олгогдоогүй цалин хөлсийг нөхөн олгох асуудлыг тавьж байгаа. Энэ оны нэгдүгээр сарын 1-нээс эхлээд УИХ-ын тогтоолоор тэтгэвэр тэтгэмж, цалин хөлс нэмэгдүүлэх асуудлаар Засгийн газарт үүрэг өгсөн. Харин төсвийн тодотголд оруулаагүй хэрнээ өөрсдөө шийдэл гаргах болохоороо тэтгэвэрийн 21 мянган төгрөгийг нэмсэн. Мөн хувьцаагаа арилжих

талаар иргэд саналаа өгч, 100 мянган төгрөг авахаар болсон, түрүүчээсээ дансанд нь ороод эхэлсэн. Гэтэл бид хүлээцтэй хандаж улс орны эдийн засгийн байдал хүндрэлтэй байгааг ойлгож ирсэн. Шаардлагатай тохиолдолд мөнгөө гаргачихдаг юм байна. Сүүлийн гурав дөрвөн жил цалин нэмэгдсэнгүй. Бараа материал, валютын ханш 50 хувиар нэмэгдлээ. Цалин хөлсний худалдан авах чадвар буурчихаад байна. Хөдөлмөрийн үнэлэмжээ нэмэгдүүлэх, худалдан авах чадварыг хамгаалах чиглэлээр Үйлдвэрчний эвлэл ажиллаж байна. Энийг боловсруулаад ямар сангаасаа гаргах нь хамаагүй өмнөх оны цалин хөлсийг олгохыг хэрэгжүүл гэмээр байна. 2015 онд төсвийн тодотголд 90 тэрбум олгох ёстой гэж орсон. 2016 оныхыг дараагийн Засгийн газар шинээр нэмэлт хэлэлцээр байгуулах чиглэлээр ажиллана. Одоо Засгийн газар авч хэлэлцээд олгоогүй цалин хөлсийг олгоочээ. Өнөөдөр төрийн алба тасралтгүй явагдах ёстой, харин сонгууль нэг л өдөр дуусна. Бүгдээрээ ажлаа орхиод, ажлаа хийхгүй, асуудлаа орхиод, хэн шийдэх нь мэдэгдэхгүй, хариугаа нийгмийн төвшинд тодорхой хугацаанд өгөхгүй байгаа нь биднийг бухимдуулж байна. УИХ-ын чуулганаар төсвийн тодотгол хэлэлцэхийг Засгийн газраас шаардаж байна” гэлээ.

АСЕМ-ын зочид төлөөлөгчдөд үйлчлэх шилдэг тогоочид тодров

Ази-Европын дээд хэмжээний 11 дэх удаагийн уулзалтын бэлтгэлийг хангах ажлын хүрээнд зочид төлөөлөгчдөд үйлчлэх, тогоочдын ур чадварыг дээшлүүлэх, үндэснийхээ хоолыг сурталчлах зорилгоор уралдаан тогооч нарын дунд зарласан. Уралдаанд хоолны жишиг цэс болон хүнсний аюулгүй байдлын талаар төрийн болон мэргэжлийн төрийн бус байгууллагаас зохион байгуулсан сургалтад 70-аас доошгүй хувиар хамрагдсан тогооч нар оролцов. Иж бүрэн өглөөний зоог бэлтгэх, Улс, үндэстний хоол, идээ, ундаа бэлтгэх, Монгол үндэстний хоол, идээ, ундааны амталгаа гэсэн шатгалсан гурван шалгаруулалттайгаар уралдааны нэгдсэн дүнг гаргалаа. Уралдааныг мэргэжлийн шүүгчдийн баг шүүж шат тус бүрийг 25

баллын зарчмаар дүгнэсэн. Онооны нийлбэр дүнгээр, “Шангрила” зочид буудлын тогооч нарын баг нэгдүгээр байр эзэлж өргөмжлөл, зургаан сая төгрөг, “Нарантуул шилтгээн” зочид буудлын тогооч нарын баг хоёрдугаар байр эзэлж өргөмжлөл, 4.5 сая төгрөг, “Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар”, “Рамада” зочид буудлын тогооч нарын баг гуравдугаар байр эзэлж өргөмжлөл 1.5 сая төгрөг, “Тушин”, “Улаанбаатар” зочид буудлын багийн тогооч нар тусгай байр эзэлж 750.000 төгрөгөөр шагнууллаа. Мөн энэ үеэр уралдаанд амжилттай оролцож, хувийн дүнгээр тэргүүлсэн тав хүртэлх тогоочийг ХХААХУ-ийн Сайдын 2009 оны 204 тоот тушаалаар батлагдсан “Монгол Улсын Мастер тогооч цол хүртэх” журмын 3.9-д заасны дагуу “Мастер тогооч” цол олголоо.

Био, Өлзийтийн чиглэлийн замд хяналт шалгалт хийж байна

Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлож буй аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагаанд нийслэлийн Тээврийн газар, Улаанбаатар хотын Цагдаагийн газрын замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах бүрэлдэхүүн хамтран тавдугаар сарын 27-ны өдрөөс эхлэн 24 цагийн турш хяналт шалгалт хийж байгаа аж. Шалгалт энэ сарын 26-ныг дуусалт үргэлжлэх юм байна. Шалгалтын хугацаанд 2070 тээврийн хэрэгсэл шалгагдснаас “БС” зөвшөөрөлгүй хөдөлгөөнд оролцсон 266, Автотээврийн хэрэгслийн хэрэглээний стандартын үзүүлэлт шаардлагыг хангаагүй 108, техникийн оношлогоо үзлэгт хамрагдаагүй 18, нийт 392 зөрчлийг илрүүлж 99 зөрчлийг газар дээр нь арилгуулжээ. Замын хөдөлгөөнд оролцож ачаа тээвэрлэж буй тээврийн

хэрэгслүүд нь Монгол Улсын нутаг дэвсгэрт мөрдөгдөж байгаа тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавигдах үндсэн шаардлагуудыг хангасан байхаас гадна автозам, замын байгууламжийн бүрэн бүтэн байдал, зам талбай бохирдуулахгүй байх /ажиж яваа ачаа нь унахгүй, асгарахгүй, гоожихгүй, хийсэхгүй байх/ бүх нөхцлийг хангаж тээвэрлэхэд нь хяналт тавьж ажиллан хүнд даацын тээврийн хэрэгслийг технологийн замаар зорчуулах ажлыг хийж гүйцэтгэж байна. Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлож буй 10 аж ахуйн нэгж, байгууллага хамтран хөрөнгө нийлүүлэн гаргаж “Тэгш план” ХХК-нар технологийн замыг сайжруулан бетонон хучилттай болгож ирэх долдугаар сарын 04-ны өдөр ашиглалтад оруулахаар болжээ.

Ч.САРАНТУЯА: ЭНЭ ЗУН ХУР БОРОО ИХТЭЙ БАЙНА

Бичин жилийн зуд, ган гэдэг ойлголт иргэдийн дунд олон янзын ойлголт төрүүлдэг. Өнөө жил муу нүүрт хэмээн бичин жил учраас зундаа гантай, өвөлдөө зуд болно гэсэн явган яриа хэдийнэ газар авчээ. Тэгвэл иргэдийн энэ таамаг яриа хэр үнэн эсэх, энэ зуны хувьд цаг агаар ямар байх талаар Цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн Урьдчилан мэдээлэх төвийн технологич, инженер Ч.Сарантуяагаас тодрууллаа.

-Энэ зун хур тунадас хэр орох төлөвтэй байна вэ. Наадмын дараа бороо орохгүй гэж хүмүүс ярих юм. Ер нь олон жилийн дунджаас хур тунадасны хэмжээ буурсан уу?

-Энэ жил хэр хур тунадас орох, гантай байх эсэхийг хэлж мэдэхгүй. Манай байгууллага өмнө нь жилд хоёр удаа цаг уурын мэдээг гаргадаг байлаа. Жилд хоёрхон удаа гаргахад бэлтгэсэн мэдээлэл тухайн өдрийн нөхцөл байдлаас шалтгаалан өөрчлөгдөх тохиолдол гардаг. Тиймээс дэлхий нийтийн жишгийг дагаж хоёр сараар гаргадаг болсон учраас өвөл ямар болохыг хэлж мэдэхгүй байна. Гэхдээ зургадугаар сард Хангай, Хөвсгөлийн уулархаг нутаг болон Говийн нутаг, зүүн өмнөд хэсгээр дундаж хэмжээнээс бага зэрэг их, бусад нутгаар дундаж хэмжээтэй, зарим газраар багавтар тунадастай байх төлөвтэй байна. Ялангуяа баруун зүгийн зарим буюу Увс, Говь-Алтай, Ховд, Завхан, Баян-

Өлгийн хойд хэсгээр багавтар тунадастай. Температурын хувьд баруун зүгийн нутгийн хойд, төвийн нутгийн зүүн хойд хэсэг, зүүн аймгийн хойд хэсгээр дундаж хэмжээнээс бага зэрэг дулаан, бусад нутгаар дундаж хэмжээтэй дулаарна. Олон жилийн дунджаас харахад, Хангай, Алтай, Хөвсгөлийн уулархаг бүс нутгаар 10-15, Өмнөд говьд 20-25, бусад нутгаар 15-20 градусын дулаантай байдаг. Нутгийн ихэнх хэсгээр дундаж олон жилийн дундаж хэмжээнд байна гэж ойлгох хэрэгтэй. Энэ сард хур тунадасны уур амьсгалын үзүүлэлт төвийн бүсийн ихэнх нутаг, зүүн аймгийн хойд хэсгээр дунджаар 50-70 мм, баруун зүгийн нутаг болон Говийн ихэнх нутгаар 30 мм, бусад нутгаар 30-50 мм бороо орсон. Өнөөдрийг хүртэл бороо их орсон. Тэр дундаа баруун зүгийн нутагт бороо ихтэй байна. Тухайлбал, Хөвсгөл, Завхан, Говийн бүс нутгаар өнөөдрийг хүртэл 30-60 мм бороо орсон. Одоо үлдэж

байгаа хугацаанд ч гэсэн бороо орох төлөвтэй байгаа. Энэ сарын 18-23-нд ихэнх нутгаар дуу цахилгаантай бороо орно.

-Долдугаар сард бороо орох уу. Бичин жилийн зун учраас бороо орохгүй ган болно гэсэн яриа яваад байна?

-Долдугаар сард бороо орно. Ер нь баруун зүгийн зарим газраар дундаж хэмжээнээс багавтар, говийн бүсийн нутгаар дунджаас их, бусад нутгаар дундаж хэмжээнд хур тунадас бороо орох төлөвтэй байна. Температурын хувьд нутгийн баруун хагас, төвийн нутгийн зүүн хойд хэсгээр дунджаас дулаан, бусад нутгаар дундаж хэмжээний орчим байна. Одоогоор бороо яг хэзээ орохыг хэлэх боломжгүй. Гэхдээ долдугаар сард бороо орно. Наймдугаар сард ч гэсэн бороо орох төлөвтэй байна. Ер нь өмнөх жилүүдээс харж байхад долдугаар сар бороотой, ялангуяа дуу цахилгаантай, усархаг аадар бороо ихтэй байдаг. Зуны гурван сарын хамгийн их бороотой нь долдугаар сар юм. Тиймээс ард иргэд үер, усны аюулаас анхаарал болгоомжтой байх хэрэгтэй.

-Жил бүр үүл харваж бороо оруулдаг шүү дээ. Энэ жилийн үүл харвах төлөвлөгөө гарсан уу?

-Ер нь монгол орны хэмжээнд зуншлага сайхан байна. Ихэнх нутгаар хур тунадас орлоо. Бид саяхан Төв

аймгийн ойролцоо харвалт хийсэн. Тэрний үр дүнд хэсэг бороотой байлаа. Гол нь газар тариалангийн бүсэд бороо оруулахад анхаарч байгаа. Ер нь жилд 1000 пуужин хэрэгцээтэй байдаг. Өнгөрсөн жил 1000 пуужин харвасан. Энэ жил мөн адил. Тариа ногооны ургалтын гол үе нь зургаа, долдугаар сард байдаг. Тиймээс энэ сард бороо оруулахаар их зүтгэж байдаг. Харин ч сайн орлоо. Жилийн жилд Монгол орны нийт газар нутгийн 80 хувь нь зуншлага сайтай, 20 хувь нь гантай байдаг. 100 хувь бүгд ногоордоггүй. Гэхдээ энэ жил өнгөрсөн жилийг бодвол их сайхан байгаа. Тухайлбал, Хөвсгөл, Архангай, Завханд хур тунадас их орсон. Одоо ч гэсэн бороотой байна. Ер нь анхаарал татаж байгаа хоёр аймаг бий. Хэнтий, Төв аймаг. Хэнтий аймагт бид дэмжлэг үзүүлж харвалт хийсэн. Төв аймагт тааруухан гэсэн. Гэхдээ өнгөрсөн жил цас их орсон учраас энэ жил зуншлага их сайхан байгаа.

-Одоогийн байдлаар хэчнээн удаа харвалт хийсэн бэ?

-Тавдугаар сарын байдлаар 150 удаагийн үйл ажиллагаагаар 300 орчим газрын генератор, 400 гаруй пуужин харвасан. Ер нь үүднийхээ массаас шалтгаалж дунджаар нэг үүлэнд дөрвөн пуужин ашигладаг. Харин газрын генераторын хувьд гурвыг хэрэглэдэг.

PHOTO NEWS



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Нийслэлд очигдөр усархаг, аадар бороо орсны улмаас үеф бууж, нийслэлийн гудамж талбай усанд автлаа. Тухайлбал, Сүхбаатар дүүргийн 13 дугаар хорооны Ногоон талбайн 6, 7 дугаар гудамжны айа, өрхүүд усанд автсан байна. Дундагаар нийслэлийн Онцгой байдлын газрын Аврах анги, тус дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал түйлэр унтраах, аврах 34 дүгээр ангийн аврагчид айа өрхүүдийн гэр, байшин, хашаанд тогтсон үерийн усыг солуулах, далан, суваг шуудууг ус чөлөөтэй урсах нэхцэл боломжоор хангаж ажиллажээ. Усархаг бороо өнөөдөр үргэлжлэх тул үерийн аюулаас сэргэлтэй байхыг албаныхан анхаарууллаа.



СЭРЭМЖЛҮҮЛЭГ


Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсоны улмаас 51 хүн нас баржээ

Улаанбаатар хотын Замын цагдаагийн газрын ЖШУХ дээр өчигдөр нийт 356 дуудлага бүртгэгджээ. Үүнээс зам тээврийн ослын 264 дуудлага бүртгэгдэж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 73 жолоочийг журамласан байна. Мөн дөрвөн жолооч согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсоны улмаас осол гаргажээ. Тодруулбал, СХД-ийн нутаг Партизаны сангийн аж ахуйн замд Т.Согтола маркийн авто машины жолооч Э нь согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодон Б жолоочтой мотоцикльтой мөргөлдөж, жолооч 42 настай эрэгтэй Б гэмтсэн хэрэг гарчээ. Манай улсад 2016 оны нэгдүгээр сарын 1-нээс зургадугаар сарын 20-ны байдлаар 248 жолооч согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ замын хөдөлгөөнд оролцож осолд өртжээ. Мөн 166 явган зорчигч согтуу үедээ замын хөдөлгөөнд оролцож, 51 хүний амь нас хохирсон байна.

ЗАВСАРЛАГА

ДЭЛХИЙН ШИЛДЭГ ЗУРАГ

ПЕЛЕ БОЛОН БОББИ МУР



Н.БОЛД

-Та бүхэн хөлбөмбөгийн түүхэн дэх хамгийн агуу мөчүүдийн нэгийг харж байна-

1970 онд зохион байгуулагдсан хөлбөмбөгийн дэлхийн аварга тэмцээний үеэр Английн шигшээ болон Бразилийн домогт ахлагч Бобби Мур болон Пеле нар бие биедээ хүндэтгэл үзүүлэн, өмсгөлөө солилцож байгаа агшныг та бүхэн харж байна. Мексикт болсон дэлхийн аварга шалгаруулах тэмцээний хэсгийн шатанд Англи болон Бразил учраа таарсан нь үзэгчдийн сонирхлыг хамгийн их татаж байсан юм. 1966 оны дэлхийн аварга Английн шигшээ баг дэлхийн хоёр удаагийн аварга Бразилтай тоглох тоглолтыг бүх

хүн тэсэн ядан хүлээж байлаа. Энэ удаагийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнийг дэлхий даяар телевизээр өнгөтөөр дамжуулж байсныг ч хэлэх үү. Хоёр багийн тоглолт хэний ч урмыг хугалахааргүй болсон. Тэр ч битгий хэл өнөөдөр ч гэсэн энэ тоглолтыг хөлбөмбөгийн түүхэн дэх хамгийн гайхалтай тоглолт байсныг олон хүн хүлээн зөвшөөрөх байх. Алан Болл, Жефф Астл, Бобби Мур, Пеле, Гордон Бэнкс гээд гайхалтай тоглогчид хоёр багийн бүрэлдэхүүнд байсан шүү дээ. Тэр дундаа Гордон Бэнксийн Пелегийн цохисон бөмбөгийг хаасан хаалт ДАШТ-ийн түүхэн дэх хамгийн гайхалтай хаалтын нэгээр нэрлэгдэх учиртай. Энэ тоглолтод Жаирзиньогийн оруулсан ганц гоолын ачаар Бразилийн шигшээ хамгийн хүчтэй өрсөлдөгчөө 1:0-ээр буулгаж авсан. Энэ тоглолтын дараа хоёр багийн

ахлагч Бобби Мур, Пеле нар өмсгөлөө солилцсон юм. Англи энэ тэмцээнд шөвгийн наймд Германд хожигдсон. Харин Бразил түрүүлж, Пеле гурав дахь удаагаа дэлхийн аварга болсон билээ. Харин домогт ахлагчдын өмсгөлөө солилцож байгаа энэхүү алдарт зургийг Америкийн гэрэл зурагчин Жон Варли авчээ. Тэднийг өмсгөлөө солилцох үеэр цөөнгүй зурагчин зураг авсан ч Жон Варлигийнх гэрэл зургийн түүхэнд үлдэж чадсан юм. "Daily Mirror" сонинны дайн болон гадаадын сурвалжлагч байсан Варни хөлбөмбөгийн үнэнч хөгжөөн дэмжигч байжээ. Тэрбээр дөрвөн жилд нэг удаа өөрийн хүслээр сонинсоосоо чөлөө авч, ДАШТ-ийг үзэж, сурвалжилдаг байсан аж. 1966, 1970, 1974, 1978, 1982 онуудад таван дэлхийн аваргыг сурвалжилж явсан алдартай сурвалжлагч юм байна.

Улаанбаатар:



Маргааш

Өдөр +20
Шөнө +7

Нөгөөдөр

Өдөр +24
Шөнө +11

Өдрийн зурхай

Аргын тооллын:

2016 оны 6-р сарын 22,
Лхагва гараг

Билгийн тооллын:

Шинийн 17. Таван шар
лэнгэтэй Хөхөгчин гахай өдөр.

Наран ургах/шингэх:

05:53 / 21:52

Үс засуулбал:

Өнгө зүс доройтно



Тухайн өдөр хонь, туулай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр эе, эвээ ололцох, хамтын хөдөлмөр эхлэх, гэрээ хэлцэл байгуулах, найр хурим хийх, бэр гуйх, инж өгөх, авах, үнэт эрдэнийн зүйл авах, нялхасын хурим хийх, сүм дуганыг сэргээх,огторгуйн үүдийг боох, их хүмүүнтэй уулзахад сайн. Газар ухах, худаг гаргах, гөлөг тэжээх, балгадын суурь тавих, нохой худалдан авахад муу. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахайболой. Хол газар яваар одогсод зүүн хойш мөрөө гаргавал зохистой. Зуны туйл болох улирал 6 цаг 57 минутад эхэлнэ. Халууны ес эхэлнэ. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

ТЭНГИС
KINO THEATRE

МАНАЙ ДЭЛГЭЦНЭЭ...

Тасалбарыг манай ТЭНГИС...



tel: 313105

www.facebook.com/tengismovie
https://ticket.tengis.mnhttps://twitter.com/tengismovie
www.tengis.mn1900-1617 -руу залгаад тасалбар захиалга,
үнэггүй хүргэлттэй боллоо